

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
	Хуралдааны товч тэмдэглэл:	1-33
	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	34-129
	1.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2021.09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	39-42 94-104
	2.Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	42-50
	3.“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2021.10.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	50-51
	4.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	51-53
	5.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2021.09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	53-65
	6. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	65-66
	7.Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	66-71
	8.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	71-72
	9.“Авлигатай тэмцэх газрын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	72-73
	10.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	73-94, 104-116
	11.Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	116-129

Хураангуй тэмдэглэл

Арав.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын Ахлах мэргэжилтэн Ж.Амгалан, шинжээч Х.Сүрэнхорол, Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын дарга Э.Эрдэнэ, Хэлтсийн дарга Д.Ганзориг, Цахим хөгжлийн үндэсний хорооны Ажлын албаны дарга С.Тэнгис, Мэдээллийн холбооны операторуудын ассоциацийн гүйцэтгэх захирал У.Тамир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга О.Номинчимэг, Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн газрын референт Г.Алтанцэцэг, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх П.Батбаатар, референт Б.Золбоо, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Хяналт шалгалт, үнэлгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Янжинхорлоо нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ц.Цэрэнпунцаг, Б.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр, Н.Энхболд нарын тавьсан асуултад Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг нар хариулж, тайлбар хийв.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 10 минут үргэлжилж, 76 гишүүнээс 58 гишүүн хүрэлцэн ирж, 76.3 хувийн ирцтэйгээр 13 цаг 13 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 02 минутад эхлэв.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны

хэлэлцүүлгийг хойшлуулж, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгээс авсан завсарлагын хугацаа дууссан тул уг асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцье гэсэн горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 18

Бүгд: 46

60.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулахаар тогтов.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбат Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./14:20/

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, М.Оюунчимэг, Ц.Туваан, Ц.Сэргэлэн нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга М.Санжаадорж нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Уг асуудлыг 14 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулав.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Нэг.Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны
дэмжсэн санал:**

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.3.1 дэх заалтын “гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагчид” гэснийг “гэр бүлийн гишүүнд” гэж, 3.3.2 дахь заалтын “гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагчийн” гэснийг “гэр бүлийн гишүүний” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 20
Бүгд: 47
57.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Х.Нямбаатар, Ж.Сүхбаатар нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.4.Гүйцэтгэх ажлын тухай хуулиар тусгайлан зохицуулснаас бусад хувь хүний нууцтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 20
Бүгд: 48
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Н.Алтанхуяг, П.Анужин, Э.Бат-Амгалан, Т.Доржханд, Л.Мөнхбаатар, Б.Саранчимэг, Ж.Сүхбаатар, Д.Цогтбаатар /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “иргэний бүртгэлийн дугаар,” гэсний дараа “хөрөнгө,” гэж нэмж, 4.1.6 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн “Иргэний хуулийн 16, 17, 18, 19 дүгээр зүйлд,” гэснийг “Иргэний хуулийн 17, 18, 19 дүгээр зүйлд хуульд өөрөөр заагаагүй бол мөн хуулийн 16 дугаар зүйлд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.2.“хүний эмзэг мэдээлэл” гэж хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг;

4.1.3.“мэдээлэл цуглуулах” гэж Нийтийн мэдээллийн тухай хуулийн 4.1.6-д заасныг;

4.1.4.“мэдээлэл боловсруулах” гэж Нийтийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасныг;

4.1.5.“мэдээлэл ашиглах” гэж Нийтийн мэдээллийн тухай хуулийн 4.1.4-т заасныг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 18
Бүгд: 48
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “мэдээлэл хамгаалахад” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 20
Бүгд: 47
57.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “утга зохиолын бүтээл туурвих,” гэсний дараа “нээлттэй өгөгдөл,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 22
Бүгд: 48
54.2 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “хуульд зааснаас бусад тохиолдолд” гэсний дараа “мэдээллийг боловсруулах, цуглуулах, ашиглахдаа” гэж, 8.2.3 дахь заалтын “боловсруулах,” гэсний өмнө “цуглуулах,” гэж тус тус нэмж, 8.2.6 дахь заалтын “мэдээллийн төрөл, агуулга” гэснийг “мэдээллийн жагсаалт” гэж, 8.2.7 дахь заалтын “цуцлах нөхцөл” гэснийг “цуцлах хэлбэр” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 20
Бүгд: 47
57.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.Энэ хуулийн 4.1.2-т заасан эрүүл мэнд, захидал харилцаа, генетик, биометрик, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх хүний эмзэг мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 21
Бүгд: 47
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтын “эрүү, иргэн, захиргааны болон бусад” гэснийг, 10.2 дахь хэсгийн “Хөдөлмөрийн

тухай хуульд нийцүүлэн тогтоосон” гэснийг тус тус хасаж, 10.2 дахь хэсгийн “ажилтны” гэсний дараа “зөвшөөрлөөр” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.5 дахь заалт нэмэх:

“10.1.5.Монгол Улсын Их Хурлын гишүүн хуралдааны ирцэд бүртгүүлэх, санал хураалт явуулах зорилгоор хүний биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг.” гэсэн саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн тул санал хураалт явуулаагүй болно.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 11.1, 11.3-т заасан зорилгоор” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	20
Бүгд:	45

55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “мэдээллийн эзний зөвшөөрлөөр” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	20
Бүгд:	43

53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалтын “бэлгийн чиг хандлага,” гэснийг “бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	18
Бүгд:	43

58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа” гэснийг хасаж, 15.1.3 дахь заалтын “цуглуулснаас” гэснийг “цуглуулж, боловсруулснаас” гэж, “эсхүл гэрээнд заасан,” гэснийг “гэрээнд заасан, эсхүл харилцан тохиролцсон” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	26
Татгалзсан:	16
Бүгд:	42

61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “мэдээллийн ангилал” гэснийг “мэдээллийн жагсаалт,” гэж, 19.4.7 дахь заалтын “мэдээлэл хариуцагчийн өгсөн үүрэг, зааврыг” гэснийг “мэдээлэл хариуцагчийн

өгсөн үүрэг, чиглэл, даалгаврыг” гэж тус тус өөрчилж, 19.3 дахь хэсгийн “шилжүүлсэн тохиолдолд мэдээлэл боловсруулагчид хүлээлгэх” гэснийг, 19.4.2 дахь заалтын “мэдээллийн эзний” гэснийг, 19.4.4 дэх заалтын “буцааж” гэснийг болон 19.6 дахь хэсгийг тус тус хасаж, 19.4.6 дахь заалтын “энэ хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу” гэсний дараа “мэдээллийн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 16
Бүгд: 42
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн гарчгийн “Аюулгүй байдлыг” гэсний өмнө “Мэдээллийн” гэж, 20.1.1 дэх заалтын “мэдээллийн аюулгүй байдлыг хангах” гэсний өмнө “энэ хуулийн 20.2-т заасан шаардлагад нийцүүлэн” гэж тус тус нэмж, 20.1 дэх хэсгийн “чиглэлээр зохион байгуулалтын болон техникийн” гэснийг “талаар” гэж, 20.1.4 дэх заалтын “мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох талаар тодорхой журам” гэснийг “мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох талаар журам” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 20
Бүгд: 42
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тохиолдол бүрд агуулгад нь тохируулан өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 20
Бүгд: 42
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалтын “мэдээллийг” гэсний өмнө “боловсруулсан” гэж нэмж, 21.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.2.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 21.1-д зааснаас бусад тохиолдолд мэдээллийн эзний мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглахад мэдэгдэл хүргүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн “бүртгэлийг жил бүр” гэснийг “бүртгэлийг жил бүрийн нэгдүгээр сард” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 15

Бүгд: 41

63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь заалтыг хасаж, 24.1.4 дэх заалтын “хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх” гэснийг “шаардлага, зөвлөмж өгөх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 18

Бүгд: 41

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “дүрс бичлэгийн” гэснийг, 27.9 дэх хэсгийн “хандаж харах,” гэснийг болон 27.11 дэх хэсгийг тус тус хасаж, 27.4.3 дахь заалтын “нийтийн зориулалттай орон сууцны” гэсний дараа “орох, гарах нийтийн хэсэг болон дундын эзэмшлийн талбайн” гэж нэмж, 27.4.1 дэх заалтын “караоке” гэснийг “караокены өрөө,” гэж, 27.4.3 дахь заалтын “дүрст хэлбэрээр түгээх” гэснийг “дүрст хэлбэрээр тараах” гэж, 27.7 дахь хэсгийн “бичлэгийн системд” гэснийг “бичлэгийн төхөөрөмж байршуулахад” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 27.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 27.2 дахь хэсэг болгох:

“27.2.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн систем нь энэ хуулийн 27.1-д заасан төхөөрөмж, мэдээлэл дамжуулах сүлжээ, хадгалах төхөөрөмж, программ хангамжаас бүрдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 18

Бүгд: 41

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 20

Бүгд: 41

51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэснийг “2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт үг хэлж, хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Хоёр.Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн найруулгын санал:

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын “хөндөөгүй тохиолдолд” гэснийг “хөндөхгүйгээр” гэж, төслийн “дүрс бичлэг” гэснийг “дүрсний бичлэг” гэж тохиолдол бүрд агуулгад нь тохируулан тус тус өөрчлөх.

2.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтын “мэдээлэлд хүний оролцоогүй цахим хэлбэрээр хийх боловсруулалт нь” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “12.1, 12.3 дахь хэсгийн “Хувь хүний нууцын тухай” гэснийг “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” гэж,” гэснийг “12.1 дэх хэсгийн “хувь хүний нууцад хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хувь хүний нууцын тухай” гэснийг “хүний хувийн мэдээлэлд хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” гэж, 12.3 дахь хэсгийн “Хувь хүний нууцын тухай” гэснийг “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41

63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Гаалийн тухай хуулийн” гэсний дараа “5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “төр, хувь хүний, байгууллагын нууцад хамаарах мэдээллийг” гэснийг “төрийн болон албаны, байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийг” гэж, “нууцын хууль тогтоомжоор” гэснийг “холбогдох хууль тогтоомжоор” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	26
Татгалзсан:	15
Бүгд:	41

63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “хүний эмзэг мэдээллийг” гэснийг “хүний хувийн мэдээллийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	18
Бүгд:	40

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсгийн “төр, байгууллага, хувь хүний нууцтай” гэснийг “төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй” гэж” гэсний дараа “, “Захидал харилцааны нууцыг” гэснийг “Захидал харилцааны мэдээллийг” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	15
Бүгд:	40

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.22 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн “дүрсний, дуу-дүрсний” гэсний өмнө “дууны,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	24
Татгалзсан:	16
Бүгд:	40

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “орон байранд” гэснийг “нийтийн зориулалттай орон сууцанд оршин сууж байгаа” гэж, 2 дахь заалтын 6.27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “мэдээллийн эзний эрх, эрх

чөлөөг хөндөж” гэснийг “мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг зөрчиж,” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.22 дугаар зүйлийн Тайлбар хэсгийн “караоке” гэснийг “караокены өрөө,” гэж өөрчилж,” “цахилгаан шат” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг,” гэснийг “38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсгийн “төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой” гэснийг “төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой” гэж, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоос” гэснийг “төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй холбоотойгоос” гэж,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “49 дүгээр зүйлийн 49.2.6 дахь заалтын “захидал харилцааны нууц” гэснийг “захидал харилцааны мэдээлэл” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “111 дүгээр зүйлийн 111.6 дахь хэсгийн “төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцад” гэснийг “байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд” гэж” гэснийг “111 дүгээр зүйлийн 111.6 дахь хэсгийн “төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцад” гэснийг “төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Прокурорын тухай хуулийн 58 дугаар зүйлийн” гэсний дараа “58.3 дахь хэсгийн “захидал, харилцаа, хувийн нууц,” гэснийг “хүний эмзэг мэдээлэл,” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 20
Бүгд: 40
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 14
Бүгд: 40
65.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан 7.1.10 дахь заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалт:

“7.1.10.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлд 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн “захидал харилцааны нууцыг” гэснийг “захидал харилцааны мэдээллийг.” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “хүний эмзэг мэдээллийг” гэснийг “хүний хувийн мэдээллийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Хүүхдийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “эрүүл мэнд, хувийн харилцааны нууц,” гэснийг “хувийн мэдээлэл,” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Хүүхдийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “эмзэг мэдээллийг” гэснийг “хувийн мэдээллийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 14
Бүгд: 40
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй 3 саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн тул санал хураалт явуулаагүй болно.

19.Ажлын хэсгийн гаргасан, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “1.11 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “захидал харилцааны нууцыг” гэснийг “захидал харилцааны мэдээллийг” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Дараагийн асуудалд орно. **Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулна.**

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны хамтарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын эрхэм гишүүн Инновац цахим бодлогын Байнгын хорооны дарга Ням-Осорын Учрал танилцуулна.

Хууль зүйн байнгын хорооны дарга Сандагийн Бямбацогт танилцуулна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн

шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2021 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2021 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 54 дүгээр захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Н.Учралаар ахлуулан, гишүүдэд Н.Алтанхуяг, П.Анужин, Э.Бат-Амгалан, Т.Доржханд, Л.Мөнхбаатар, Б.Саранчимэг, Ж.Сүхбаатар, Д.Цогтбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах дэд ажлын хэсэгт холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан ажилласан байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсэгт заасны дагуу Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хороо 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хамтарсан хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасны дагуу Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг завсарлага авсан болно.

Дээрх завсарлагын хугацаа дуусгавар болсноор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсэгт заасны дагуу Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хороо 2021 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хамтарсан хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулж, хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Ажлын хэсгээс хуулийн төсөлтэй холбогдуулан нэр томъёог Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөлтэй нийцүүлсэн бөгөөд хөрөнгийн мэдээллийг хүний эмзэг мэдээллээс хасаж хүний хувийн мэдээлэлд хамааруулахаар, Иргэний хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, 16.4 дэх хэсэгт заасан бүрэн бус чадамжтай иргэнд хувийн мэдээллээ ашиглахад шаардлагатай тодорхой төрлийн эрхүүдийг нээж өгөх, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад “нээлттэй өгөгдөл” бий болгох асуудлыг нэмж тусгах, сэтгүүл зүйн зорилгоор нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглахдаа мэдээллийн эзний зөвшөөрлийг авахгүй байх талаар, Хүний эрхийн Үндэсний Комисс Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавихдаа зөвлөмж, шаардлага хүргүүлэх талаар, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлэн Харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болгох талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн хуралдааны ирцэд бүртгүүлэх, санал хураалтад оролцохдоо хүний биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг ашиглах талаар нийт 21 зарчмын зөрүүтэй санал, 1 найруулгын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Түүнчлэн ажлын хэсгээс Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн

шинэчилсэн найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 1 санал, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 2 санал, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 1 санал, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 5 санал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 1 санал, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 2 санал, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 1 санал, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 2 санал, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 1 санал, Хүүхдийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 2 санал, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 3 санал, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 1 санал боловсруулсныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар зүйлийн 3.3.1 дэх заалтын “гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагчид” гэснийг “гэр бүлийн гишүүнд” гэж, 3.3.2 дахь заалтын “гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагчийн” гэснийг “гэр бүлийн гишүүний” гэж тус тус өөрчлөх, мөн Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Х.Нямбаатар, Ж.Сүхбаатар нараас 3.4 дэх хэсгийг “Гүйцэтгэх ажлын тухай хуулиар тусгайлан зохицуулснаас бусад хувь хүний нууцтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулна.” гэж өөрчлөн найруулах зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Ц.Сэргэлэн, Ш.Адьяа, Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар, С.Бямбацогт, Ц.Сандаг-Очир, Б.Энх-Амгалан, Н.Алтанхуяг нар хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томьёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Н.Алтанхуяг, Ж.Сүхбаатар нар хуулийн төслийн 27 дугаар зүйлд заасан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн системийг хууль бусаар, бусдыг дарамтлах зорилгоор ашиглаж байвал эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хуульд заасан хариуцлагыг нэмэгдүүлэх талаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулахыг анхаарах нь зүйтэй талаар саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хороо ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Барсүрэнгийн Баасандорж Хуул зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Пүрэвжавын Сайнзориг, Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын дарга Энхнасангийн Эрдэнэ ээ, Хууль зүй, дотоод хэргийн яамны Мэдээллийн технологийн газрын дарга Даваанямын Ган-Эрдэнэ, Тагнуулын ерөнхий газрын мэдээллийн аюулгүй байдлын газрын хэлтсийн дарга Даваадоржийн Ганзориг, Харилцаа холбоо мэдээллийн технологийн газрын Мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын газрын дарга Бадамдоржийн Бэлэгдэмбэрэл, Цахим хөгжлийн үндэсний хорооны ажлын албаны дарга Сүхээгийн Тэнгис.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Баагаагийн Баттөмөр гишүүнээр тасаллаа.

Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууна.

Г.Тэмүүлэн: Энэ хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай гээд хуулийн шинэчилсэн найруулга. Сая өнгөрсөн зун 7 сарын 5-нд Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцсэн. Хэлэлцэх эсэхийг бид бүхэн одоо Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэж байхад бол зарчмын зөрүүтэй хэд хэдэн саналуудыг Улсын Их Хурлын гишүүд гаргаж байсан, гаргаж байсан.

Би яг энэ хүний генетикийн мэдээлэлтэй холбоотой асуудлаар тодорхой саналыг бол хэлсэн. Та бүхний энэ хууль дээр томъёолж оруулж ирснээр 10.1.3, 10.1.4, залгуулаад 13.2 гэдэг юм уу. Эдгээр заалтууд бол зарчмын хувьд зөвшөөрч болохгүй заалтууд байна. Энэ хууль дээрх зохицуулалтыг бол бид нар зайлшгүй өөрчлөх ёстой гэдэг асуудлыг тавьсан. Өнөөдөр хүний генетик мэдээлэл гэдэг бол өөрөө хамгийн чухал үнэ цэнтэй мэдээлэл байдаг. Тухайн хүний бие махбод нь байгаад байгаа юм, эд эс нь байгаад байгаа юм, ДНК ч гэдэг юм уу. Ерөөсөө хамгийн үнэ цэнтэй, хүний хамгийн эмзэг, хувийн эрүүл мэндтэй холбоотой ийм мэдээллүүд байгаа. Гэтэл энэ хүний энэ генетикийн мэдээллийг та бүхэн энэ хуулийнхаа хүрээнд болбол цуглуулах гээд байна аа, ашиглах гээд байна аа.

Хүний хамгийн эмзэг хувийн мэдээллийг та бүхэн хамгаалах биш эсрэгээрээ ашиглуулах, цуглуулах, цаашид магадгүй өөр ямар нэг зорилгоор одоо боловсруулах гэдэг юм уу, энэ түвшинд энэ хуулийг чинь аваачих гээд байна.

Тэгэхээр би энэ зохицуулалт чинь буруу байна шүү дээ гэдэг зарчмын зөрүүтэй саналыг бол хэлсэн, хэлэлцэх эсэхэд. Ажлын хэсгийн түвшинд

ажиллахдаа хэлэлцүүлгийн явцад эдгээр асуудлуудыг зөв томьёолж, засаж залруулж оруулж ирэх ёстой гэдэг саналыг хэлсэн. Гэтэл бүх заалт хэв хэвээрээ байна. Чуулган дээр гишүүдийн хэлсэн зарчмын зөрүүтэй саналууд бол энэ саналуудыг та бүхэн маань анхаарч үзээгүй байна. Би тодорхой энэ заалтуудыг хэлэх гээд байна л даа.

10.1, 10.1.3 энэ юу вэ гэхээр гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, шалган шийдвэрлэх зорилгоор бол энэ хүний генетик мэдээллийг цуглуулна гэж байгаа юм. Генетик мэдээллийг цуглуулна гэж байгаа юм. Энэ өөрөө яагаад энэ гэмт хэргийг илрүүлэхэд, өөрөө энийг ашиглах гээд байгаа юм гэдэг нь тодорхойгүй болчхоод байгаа юм.

Дээрээс нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэргийг хянан шийдвэрлэхэд ашиглана гэж байгаа юм. Би эрүү дээр бол ойлгож байна, энэ генетикийн мэдээллийг. Гэтэл иргэн дээр, захиргаан дээр бол яагаад ашиглах гээд байгааг бол ойлгохгүй байгаад байгаа юм. За иргэн дээр ганцхан тохиолдол байгаад байгаа юм. Эцэг тогтооход. Гэтэл иргэний хэрэг гэдэг чинь бол эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргаантай холбоотой асуудлыг шийдвэрлэж байгаа юм. Захиргааны хэрэг, захиргааны хэрэг бол зөвхөн зүгээр тухайн хуулийн этгээд болон иргэн хоорондын маргааны асуудлыг шийдвэрлэхэд. Гэтэл захиргааны хэргийг шийдвэрлэхэд тэр генетикийн мэдээллийг цуглуулж, тэрийг боловсруулж тэрийг ашиглаж яах гээд байгаа юм бэ. Энэ бол хэрэг хянан шийдвэрлэхэд хамгийн хүний үнэ цэнтэй хамгийн эмзэг мэдээллийг та бүхэн цуглуулж ашиглах гээд байгаа нь асуудлыг бол би ерөөсөө зарчмын хувьд ойлгохгүй, дэмжихгүй байгаа.

Гуравт, 13.2 дээр мэдээллийн эзэн нас барснаас хойш 70 жил өнгөрсөн тохиолдолд хүний эмзэг мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахад зөвшөөрөл шаардахгүй ээ гэж байгаа юм. Хүний генетикийн мэдээллийг цуглуулаад 70 жилийн дараа нас барсан бол ямар нэг зөвшөөрөл шаардахгүйгээр, тэрийг бол боловсруулна, ашиглана, цуглуулна гэдэг асуудал орж ирээд байгаа юм. Бид нар хүн нас барсны дараа ч гэсэн хүний ёсоор бол хүндэтгэх ёстой. Адаглаад энэ булш сүйтгэх гэмт хэрэг гэдэг асуудал чинь Эрүүгийн хуульдаа ч гэсэн заачихсан байгаад байгаа шүү дээ. Тэрийг ухах төнхөх гэдэг чинь өөрөө хуулиараа хориотой, эрүүгийн зөрчилд орж байгаа асуудал байгаад байгаа юм. Энэ асуудлыг нээж байгаа юм уу?

Эсвэл 70 жилийн дараа 70 жилийн өмнө нас барсан тэр хүний мэдээллийг үр ач зээ нарт нь тохох гээд байгаа юм уу. Хэрэг хянан шийдвэрлэхэд.

Г.Занданшатар: Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Ням-Осорын Учрал хариулна.

Н.Учрал: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. Энэ хуулийн гол онцлог, үзэл баримтлал нь бол өмнөх хуулиар Хувь хүний нууцын хуулиар мэдээллийг цуглуулаад боловсруулаад ашиглаж байгаа тал буюу мэдээлэл хариуцагч, хариуцлага хүлээдэггүй байсан бол энэ удаагийн хуулиар мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа тал хариуцлага хүлээх тэр үүрэг нь их тодорхой болж өгч байгаа.

Тэгэхээр яг одоо энэ Тэмүүлэн гишүүний хэлдгээр биометрик болон генетик мэдээллийг цуглуулж, боловсруулж ашиглаж байгаа тал бол энэ хуулиар

хариуцлага хүлээх болж байгаа. Тэгэхээр ямар тохиолдолд одоо энэ биометрик генетик мэдээллийг цуглуулах вэ гээд дор дурдсан шаардлагууд буюу 10.1, 2, 3, 4, 5 дахь заалтыг нь хуульд тусгаж өгсөн.

Энд бол онцлогтой юм байгаа юм. Жишээ нь улсын бүртгэлийн байгууллага дээр Сонгогчийн бүртгэлийг хянах зорилгоор бол хүний биеийн давхцахгүй өгөгдлийг буюу баруун гарын хурууны хээг авдаг. Хил хамгаалах байгууллага дээр нь хил нэвтрэхэд бол тухайн хүний таньж мэдэх, баталгаажуулах зорилгоор гарын хурууны хээг авна. Мөн хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны явцад мөн шүүхийн шинжилгээний байгууллага хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцдаа бол энэ шүүхийн шинжилгээ хийхэд биометрик генетик мэдээллийг зөвхөн дор дурдсан таван тохиолдолд авна.

Гэхдээ ингэж авахдаа мэдээллийн эзний зөвшөөрлөөр боловсруулна гэдгийг нь харин хуульчилж өгөхөөр хувь хүний мэдээллийг хуулиар хамгаалж байгаа юм. Өмнө нь бол Хувь хүний нууцын хуулиар зөвхөн тэр иргэн өөрийнхөө мэдээллийг хамгаалдаг байсан бол одоо цуглуулж боловсруулж ашиглаж байгаа бол та тэр хүний мэдээллийг хамгаалах ёстой гэдэг үүргийг нь энэ хуульд тодорхой болгож байгаа. Тэгэхээр хүний эмзэг мэдээлэлд хамаарагдаж байгаа буюу биометрик генетик мэдээллүүд бол зөвхөн дор дурдсан 5 тохиолдолд ашиглана, цуглуулна боловсруулна.

Гэхдээ заавал мэдээллийн эзний зөвшөөрлийг шаардана. Зөвшөөрөөгүйгээр энэ мэдээллийг одоо боловсруулахыг хориглоно гэж байгаа юм. Тэгэхээр энэ зохицуулалт орсноороо бол харин ч эсрэгээрээ одоо таны яриад байгаагийн эсрэгээр хувь хүний мэдээлэл хамгаалагдаж байгаа. Энэ хууль гарахгүйгээр ингээд яваад байх юм бол мэдээллийг цуглуулж байгаа, боловсруулж байгаа, ашиглаж байгаа тал ямар ч хариуцлага хүлээхгүй. Мэдээллийн хариуцагчийн үүрэг нь тодорхой бус яваад байдаг. Ингээд мэдээллийг цуглуулж боловсруулж байгаа мэдээлэл хариуцагч тал мэдээллийг алдах юм бол тухайн иргэний мэдээлэл алдагдаад юуных нь уршигт бол тухайн иргэнд тэр ялгаварлан гадуурхал бий болгох ч гэдэг юм уу нөхцөл байдлууд үүсдэг. Тэгэхээр энэ хууль гарснаараа зөвхөн дараах таван тохиолдолд тэр хүний давхцахгүй өгөгдөл биометрик генетик мэдээллийг ашиглана шүү. Тэгэхдээ ашиглахдаа дараах таван тохиолдол юм гээд ингэж хуульчилж өгч байгаа. Жишээ нь тэр хэрэг маргааныг хянан шийдвэрлэх гэдэг ажиллагааны явцад гэдэг асуудалд 10.1.4 дээр бид зарчмын зөрүүтэй саналаар бол өнөөдөр эрүүгийн хэргийн, захиргааны болон бусад гэдгийг нь хасаад хасах саналтайгаар орж ирж байгаа.

Шүүхийн шинжилгээний байгууллага хэрэг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийн шинжилгээ хийх шаардлагатай бол биометрик генетик мэдээллийг ашиглах ёстой. Яагаад гэвэл хэргийг илрүүлэх гэж байгаа учраас. Тэгэхдээ энийг дурын нэг хүн биш зөвхөн шүүхийн шинжилгээний байгууллага, тэгэхдээ мэдээллийн эзнээс зөвшөөрөл авна. Мөн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, шалган шийдвэрлэх зорилгоор бас энэ мэдээллийг цуглуулж боловсруулдаг. Хэргийн үнэн мөнийг тогтоохын тулд. Тэгэхээр мөн энэ тухайн тусгайлсан байгууллага нь эзнийх нь зөвшөөрлөөр, энэ тохиолдолд хилээр гарахад нөгөө бүртгэлийн байгууллага нөгөө сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийг хянах зорилгоор гээд. Энэ бол хүний хувийн мэдээллийг харин эсрэгээрээ хамгаалж өгч байгаа шүү гэдгийг хэлье.

13 дугаар зүйл дээр асуулт асуусан. Тэгэхээр мэдээллийн эзнийг нь нас барсны дараа мэдээллийг цуглуулах гэвэл тэр нь болохоор юу вэ гэхээр мэдээллийн эзэн нас барсан тохиолдолд бол бас түүний гэрээслэл, эсвэл гэр бүлийн гишүүн хуульд төлөөлөгчийн бичгээр зөвшөөрснөөр мэдээллийг цуглуулж, боловсруулж ашиглана. 70 жилийн дараа байгаа тохиолдолд бол тэр чинь одоо тухайн хүний одоо түүх хийж байсан үйл хэрэгтээ холбогдуулаад ер нь ашиглаж болно оо л гэдэг.

Г.Занданшатар: Тэмүүлэн гишүүн тодруулж асууя.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр 13.2 дээр бол яг хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн эзэн нас барснаас 70 жил өнгөрсөн тохиолдолд хүний эмзэг мэдээллийг цуглуулж боловсруулах, ашиглахад зөвшөөрөл шаардахгүй ээ гэдэг асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр бид нар энэ Үндсэн хуулиараа ч гэсэн ер нь энэ үл ялгаварлах зарчмыг бол тусгаж өгсөн. Хувь хүнтэй холбоотой үндэс угсаатай холбоотой, хувь хүний мэдээлэлтэй холбоотой асуудлыг ч гэдэг юм уу, хүний хувийн өмчтэй холбоотой асуудлууд дээр.

Тэгэхээр бид нар адаглаад энэ хүн нас барсны дараа ч гэсэн хүний ёсоор хандах ёстой гэдэг асуудал байгаад байгаа юм л даа. Энэ заалт бол би зарчмын хувьд ерөөсөө ямар ч хэрэггүй заалт гэж хараад байгаа юм. Монгол ёсонд ч тийм сургаал, уламжлал угаасаа байгаа. Тийм учраас бид нар энэ эрүүгийнхээ хууль дээр ч гэсэн энэ булш сүйтгэх асуудлыг гэмт хэрэг гэдгээр бол тусгаж өгч байсан. Тэгэхээр магадгүй 70 жилийн дараа тэр хүний булшийг ухаад тухайн тэр мэдээллийг нь цуглуулаад магадгүй хэрэг хянан шийдвэрлэхэд ашиглах гээд байгаа энэ дүр зураг гараад байна аа. Хилс хэрэг тохих ч юм уу.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал гишүүн Байнгын хорооны дарга асуултад хариулъя.

Н.Учрал: Одоо 1921 оны ардын хувьсгалыг Сүхбаатар жанжин удирдаж байсан. Тэр хүн, тэр газар төрсөн овог нэр тэгээд тэр хүн одоо боловсролын хувьд ийм хүн байсан ч гэдэг юм уу. Ингээд бичихэд мэдээллийн эзний зөвшөөрөл шаардах байж болохгүй л дээ. Тэгэхээр хүн бас нас барснаар 70 жилийн дараа бол энэ чинь тухайн хүний үйл хэрэгтэй холбогдуулаад зөвхөн биометрик генетик мэдээлэл биш энэ дотор хүний мэдээлэл дотор бол тэр үндэс угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд. Ингээд л маш олон мэдээллүүд багтаж байгаа юм. Тэгэхээр үүний дараа бол мэдээллийн эзэн зөвшөөрөл авна гэдэг бол маш ихт бэрхшээлтэй.

Энэ бол нөгөө түүхэн эх сурвалжуудыг ч гэсэн гаргаж тавихад судалгаа шинжилгээ хийхэд тухайн хүний талаар мэдээллийг цуглуулах эрх бол тэр судлаачдад шинжилгээ хийж байгаа хүмүүст үүсэж байгаа учраас ийм зохицуулалт хийж өгөхгүй бол заавал гэрээслэлээр нь заавал одоо тухайн хүний үр хүүхдээс нь зөвшөөрөл аваад тухайн хүнийг хувьсгалт үйл хэрэгт яаж оролцсон бэ гэдгийг асууна тодруулна гэдэг.

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн тодруулж байна.

Г.Тэмүүлэн: Үгүй ээ, энэ яах вэ, зүгээр хүн ёсны л асуудлын л одоо зүйл байгаа. Хүний өмч хөрөнгөтэй холбоотой, хүний өөрийнх нь мэдээлэлтэй холбоотой эцэг эх, өвөө эмээтэй нь холбоотой асуудал хүний сэтгэл зүйтэй шууд холбоотой асуудал. Тэгэхээр тэр өвөө эмээ, хамаатан садан ч гэдэг юм уу, тэдгээрийнх нь генетикийн мэдээллийг цуглуулах, зөвшөөрөлгүйгээр авч ашиглах гэдэг юм уу, энэ өгөх, ашиглуулах гэдэг энэ асуудал чинь бол тэр үлдсэн үр хүүхдүүд нь хамааралтай асуудал байхгүй юу. Үлдсэн үр хүүхдүүд нь хамааралтай, хамаатан саданд хамааралтай асуудал. Тэр мэдээллийн үр дүнгийнх нь ач холбогдол нь тэр үр хүүхдүүд нь, хамаатан саданд нь бас шууд хамааралтай асуудал байхгүй юу. Үр дүн нь. Тэгэхээр энэ би үр дүнгийн ач холбогдлыг ярих гээд байгаа. Магадгүй сөргөөр ашиглаж магадгүй, зөвөөр ашиглаж магадгүй. Сөргөөр ашиглаад танай өвөө эмээ чинь тийм ДНК-тай, тийм, одоо юу гэдэг юм өгөгдөлтэй, тийм удамшилтай хүмүүсүүд байсан. Тэгэхээр та бол тийм байна гээд.

Дараа нь магадгүй одоо хэн нэгнийг нь яллаад байх асуудал гарах уу? Тийм л эрсдэл үүсэх зүйл болчихоод байна шүү дээ. Эсвэл тэр хүн заавал гэрээслэл үлдээсэн.

Г.Занданшатар: Барсүрэнгийн. Баасандорж Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга 81.

Б.Баасандорж: Тэмүүллийн гишүүний асуултад хариулъя Баасандорж.

13.1 дээр бол гэр бүлийн гишүүдээс нь зөвшөөрөл авч цуглуулж, боловсруулж, ашиглаж болохоор хийж өгсөн байгаа. Өөрөөр хэлбэл, 70 жил дотроо тухайн одоо нас барсан хүний мэдээллийг ашиглах юм бол гэр бүлийн гишүүдээс зөвшөөрөл авахаар. Бид нар 13.2 дээр, хуульд өөрөөр заагаагүй бол 70 жил өнгөрсөн тохиолдолд энэ одоо хүний эмзэг мэдээллийг ашиглуулахаар хийчихсэн. Мөн хууль тогтоогчдоос 2019 онд архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийг баталж өгсөн. 2020 оноос хэрэгжиж эхэлсэн ийм хууль байгаа.

Энэ хуулийн 31.3 дээр иргэний намтар түүхэнд холбогдох архивын баримтыг үүсэж бий болсноос хойш 70 жил өнгөрсний дараа эрдэм шинжилгээ, судалгааны зорилгоор ашиглаж болно гээд. Тэгэхээр бид нар бас энэ архив, албан хэрэг хөтлөлттэйгөө холбоотой хуультайгаа нийцүүлээд энэ 70 жил гэдэг хугацааг хийж өгч байгаа юм. 70 жил дотор бол Тэмүүлэн гишүүний гэр бүлийн гишүүдээс нь заавал зөвшөөрөл авч байгаа. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бол тусдаа хуулиар энэ өөрөө процессынхоо хуулиар явна. Энэ бол зөвхөн эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр ашиглахаар бол 70 жил өнгөрсөн бол нээлттэй болно.

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн.

Ц.Цэрэнпунцаг: Энэ нэг хоёр тодорхой. Одоо ерөнхий ч юм уу нэг асуулт асууя. Ер нь энэ зүгээр энэ хууль, бид нар хийж байгаа шинэчилж найруулж байгаа бол энэ мэдээж олон асуудлыг шийдэхэд зорьж байгаа. Тэгэхдээ энэ гол зарчим байх ёстой гэж боддог юм. Энэ төр бол бас нэг ялангуяа энэ мэдээлэлтэй холбоотой энэ асуудал дээр бол энэ мэдээллийн эзэн, мэдээлэл эзэмшигч хоёрын хооронд л одоо мэдээллийн хувьд бол зөрүүтэй байгаа юм. Ер нь энэ орчин үеийнхээ технологи, энэ нийгмийн хөгжилтэй холбоотой байгаа юм.

Жишээлбэл эзэмшигч нь өөрөө би ямар мэдээлэл надад байгаагаа одоо мэдээллийн эзэн эзэмшигчээс дутуу мэдээлэлтэй байгаа юм. Тэгэхээр энэ хуулиар төрийн зүгээс бол энэ мэдээллийг бид нар тэнцвэржүүлж өгөх ёстой юм. Мэдээлэл эзэмшигчид байгаа ямар мэдээлэл байгааг мэдээллийн эзэн мэдэж байх ёстой. Жишээлбэл энэ өнөөдөр технологийн компаниуд, жишээлбэл хаана өдөр тутмын амьдрал нь сар, жилд энэ хүний өдөр тутам хаагуур явж, яаж амьдардаг юм, ямар үйлдэл хийдгийг уншиж байгаа шүү дээ. Тийм ээ. Нөгөө ухаалаг программын тусламжтайгаар. Тэгэхлээр энийг засаж, энэ ард иргэдийг энэ мэдээллийн эздийг тэр мэдээлэл эзэмшигчтэй адил хэмжээнд мэдээлэлтэй болгох чиглэл рүү энэ хууль яг ямар ямар заалтуудаар энийг засаж залруулж байгаа юм, нэгт.

Хоёрт гол миний итгэх асуудал бол энэ мэдээлэл эзэмшигчид ямар мэдээлэлтэй байгаа юм тэр ямар мэдээлэлтэй байгааг бүрэн мэдэх энэ боломжийг энэ хуулиар одоо олгох ёстой. Энэ рүү чиглэсэн байх ёстой гэж бодож байна.

Хоёрт, за энэ мэдээлэл нь нэгэнт одоо эзэмшигчид мэдээллийн эзэн мэдээллээ ямар мэдээлэл байгаагаа мэдсэний дараа бол энийгээ хамгаалах шаардлага гарч ирж байгаа. Тийм ээ. Энэ хууль ч угаасаа мэдээлэл хамгаалах талд энэ хамгаалах хууль гэж байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ хамгаалах эрх бүхий байгууллага гэдэг дээр ерөөсөө хоёр байгууллага тавьчихаж. Хүний эрхийн Үндэсний Комисс гээд. Тэгээд энэ цахим орчинд бол одоо харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх гээд. Энэ чинь өөр бас энэ мэдээллийг хамгаалдаг олон байгууллага байна шүү дээ. Энэ иргэний нийгэм, иргэний нийгмийн байгууллагууд чинь хаачсан юм бэ? Энэ иргэний нийгэм чинь хаана нь байгаа юм? Бид нар энэ олон нийтийн байгууллага энэ иргэний нийгмийнхэн дээ энэ мэдээлэл хамгаалах энэ эрхийг нь бас өгч болохгүй юу? Яагаад одоо энэ хоёр төрийн байгууллага тавьчихсан юм.

Ер нь хамгийн мэдээллийг авч ашиглаж ашиглаж энийг буруугаар ашиглах хамгийн одоо эрсдэл ихтэй газар бол энэ төр шүү дээ. Тэгээд төрийн энэ давамгайл байдал үүсэж энэ ард иргэдийн эрхэнд халдахаас энэ хуулиар яаж хамгаалах гээд байгаа юм. Тэр эрх хамгаалах хоёр байгууллага нь одоо Хүний эрхийн Комисс. Энэ мэдээллийн төв, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн одоо захиргааны байгууллага одоо энэ шинээр шинээр байгуулагдах яам нь байх юм уу. Энэ асуултуудад хариу авъя.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Ням-Осорын Учрал.

Н.Учрал: Цэрэнпунцаг гишүүн мөн чухал санаа хөндөж байна. Тэгэхээр энэ хуулиар бол яг мэдээлэл цуглуулж байгаа, боловсруулж байгаа, ашиглаж байгаа тэр тал буюу мэдээлэл хариуцагч тал үүрэг хүлээнэ ээ гээд байгаа юм. Тэгэхээр энэ юу вэ гэхээр мэдээлэл хариуцаж байгаа тал гэхээр маш олон талууд бий. Зөвхөн даруй төрийн байгууллага ч биш, одоо ажил олгож байгаа ажил олгогч нар ч гэсэн ажилтнуудаасаа мэдээллийг цуглуулж л байдаг. Одоо ямар нэгэн байгууллага бол эд иргэдээсээ мэдээллийг цуглуулж л байдаг. Төрийн байгууллага болгон бол бас төрөл бүрийн өөр өөрийнхөө үйл ажиллагааны чиглэлээр мэдээллийг цуглуулж байгаа. Тэгээд тэр байгууллага болгон буюу мэдээлэл цуглуулж боловсруулж байгаа тал энэ хуулиараа мэдээлэл хариуцагч тал буюу тэр үүрэг хүлээх нь тодорхой болоод мэдээллээ хариуцах болж байгаа юм. Нэг ёсондоо таны

мэдээллийг таны зөвшөөрлөөр цуглуулсан, боловсруулсан, ашигласан бол тухайн байгууллага мэдээлэл хариуцагч хариуцлага хүлээнэ гэж.

Дээрээс нь одоо төрийн үйлчилгээ цахимжиж байгаа үед таны иргэний үнэмлэхийг таны гадаад паспортын мэдээллийг таны гэрлэлтийн гэрчилгээний мэдээллийг оршин суугаа байр, газар юу байдаг юм, бусад бүх мэдээллүүдийг төр ашиглаж байгаа юу, үгүй юу гэдэг талаар мэдээллийг өөрөө мэдэж байхгүй бол миний мэдээллийг өөр зорилгоор ашиглаж байх вэ гэдэг дээр иргэд бол санаа зовж байгаа. Нэг ёсондоо төр өөртөө цугларсан мэдээллийг иргэдээсээ нэхэхгүй байна гэдэг чинь үүний цаана мэдээллийг төр өөрөө хамгаалах ёстой.

Хамгаалахдаа бол та одоо жишээ нь газрын гэрчилгээ хүслээ гэхэд таны иргэний үнэмлэхийг хэрэглэлээ гэвэл мэдэгдлийг одоо хүргүүлэх буюу нөгөө нотификэйшн ирүүлнэ гээд байгаа заалт энэ хуульд байгаа. Жишээ нь та ийм төрийн үйлчилгээ авах гэж байна, энэний тохиолдолд таны гэрлэлтийн баталгааны чинь мэдээллийг бид ашигласан гээд таны гар утсаар и мэйлээр ч юм уу ингээд мэдэгдэл хүргэнэ. Тэгэхээр энэ хууль гарснаараа таны төр таны ямар ямар мэдээллийг ашиглаад юуны тулд хэрэглэсэн бэ гэдэг талаар бүрэн ойлголттой болно. Үүнээс ангид өөр байдлаар хэрэглэх юм бол энэ хуулиар зөвшөөрөгдөхгүй. Зорилго нь тодорхой байх ёстой.

Тэгэхгүйгээр, энэ мэдээлэл өөрөө одоо дэлхий нийтийн хамгийн том баялаг болсон учраас энэ мэдээллийн дата бааз дээр сууриалаад янз бүрийн ашиг орлого олох, амьжиргааны түвшин тодорхойлох, бизнес хийх ийм сэдэл сонирхлууд бий болгохыг үгүйсгэхгүй байгаа учраас бид мэдээлэл хариуцагч үнэхээр цуглуулж байгаа, боловсруулж байгаа, ашиглаж байгаа бол хариуцлагаа хүлээ гэдэг байдлаар энэ хуульд хийж өгсөн.

Хүний эрхийн Үндэсний Комисс, харилцаа холбооны яамны зүгээс бол жишээ нь одоо мэдээллийг янз бүрээр цуглуулж байна. Одоо дууны бичлэг хийж байна, дүрсний бичлэг хийж байна, дуу дүрсний бичлэг хийж байна. Тэгэхээр энэ хуульд дууны бичлэгийг хаана хийж болох юм, дүрсний бичлэгийг хаана хийж болох юм, дуу дүрсний бичлэг хаана тавигдах юм бэ гэдгийг нь хуульчилж өгч байна.

Тэгэхээр энэ хуульчилсныхаа дагуу хаана хэрхэн байршуулах вэ, ямар стандартынх нь камер байршуулах вэ гэдэг талаарх тусгай стандартыг нь Хүний эрхийн Үндэсний Комисс тэр олон улсын гэрээ конвенцдоо сууриалаад саналаа Харилцаа холбооны яаманд өгөөд харилцаа холбооны яам нь тэр саналыг үндэслээд журмаа гаргана. Ингээд журмаа гаргахаар Харилцаа холбооны яамнаас батлагдсан журмын дагуу ямар төхөөрөмж байрших юм. Ямар дууны төхөөрөмж хаана, яаж, хэрхэн байршсанаараа хүний эрхийг зөрчихгүй байх юм бэ? Одоо өөрт нь хувийн орон зайд нь халдахгүйгээр энэ мэдээллийг одоо хэрхэн цуглуулах юм бэ? Цуглуулж байгаад цуглуулж байх явцад тэр мэдээллийг алдсанаасаа болоод тухайн хувь хүний хүний эрх зөрчигдөөд, нийгэмд ялгаварлан гадуурхах байдал үүсдэг ээ.

Тэгэхээр үнэхээр та цуглуулж байгаа, боловсруулж байгаа, ашиглаж байгаа бол ямар ч байгууллага, хэн ч бай мэдээлэл хариуцагч та энэ хуулиар хариуцлага хүлээнэ. Хариуцлага нь бол энэ хувь хүний нууцын мэдээллийг алдсан бол цаашаа дамжуулсан бол та Зөрчлийн хуулиараа тэгээд Эрүүгийн хуулиараа хариуцлага

хүлээх, дагах хуулиуд нь энэ хуулиар орж ирж байгаа. Ер нь энэ хууль бол бүхэлдээ хүний эрхийг хамгаалсан бас аюулгүй байх, халдашгүй байх, хувь хүний мэдээллийг хамгаалсан ийм бас дэвшилтэт хууль болж байна гэж харж болно.

Г.Занданшатар: Цэрэнпунцаг гишүүн нэмэлт нэг минут.

Ц.Цэрэнпунцаг: Учрал гишүүнээ ер нь зүгээр миний асуусан агуулга нь бол жишээлбэл одоо хувийн мэдээллийг цуглуулж байгаа нэг бизнесийн байгууллага нөгөө мэдээллийн эзэнд одоо ямар хэлбэрээр тэр мэдээллийг нь ийм мэдээллийг чинь ашиглаж байгааг, мэдээлэл өгөх тэр заалт, зүйл заалтууд энд байгаа юм уу, тэр харилцааг энд одоо тусгаж өгсөн юм байна уу гэж нэгт.

Хоёрдугаарт миний энэ хоёр дахь асуултад хариулсангүй. Энэ иргэний байгууллагууд тийм ээ, төрийн бус байгууллагуудад энэ дээр яагаад энэ эрхийг нь өгч хамгаалах эрхийг нь бас давхар өгч болохгүй байгаа юм.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал гишүүн хариулна. Дараа нь Баасандорж.

Н.Учрал: Энэ Хүний эрхийн Үндэсний Комиссын үүргийг 24.1 дэх заалтаар тодорхойлж өгсөн. Хүний хувийн мэдээлэл хамгаалах, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, олон нийтэд таниулж, сурталчлах ажлыг зохион байгуулах, энэ талаар холбогдох байгууллагад санал хүргүүлэх гээд ингээд тодорхой нөхцөлүүдийг нь энэ 24 дүгээр зүйл дээр тавьж өгсөн. Тэр иргэний нийгмийн байгууллагууд бол одоо Хүний эрхийн Үндэсний Комисстойгоо хамтарч ажиллаад явж болно.

Дээрээс нь шаардлагатай зөвлөмжүүдээ хүргүүлж болно. Гэхдээ зөвхөн нэг байгууллага биш мэдээлэл цуглуулж байгаа, боловсруулж байгаа, ашиглаж байгаа тал бол бүх л байгууллага цуглуулж л байгаа бол, боловсруулж байгаа бол ашиглаж л байгаа бол бүх байгууллага буюу мэдээлэл хариуцагч үүрэг энэ хууль дээр одоо тодорхой бас орж өгсөн. Тэгээд ажлын хэсэг нэмж хариулах байх.

Г.Занданшатар: 81 Барсүрэнгийн Баасандорж Төрийн нарийн бичгийн дарга хариулна.

Б.Баасандорж: Ажлын хэсгийн ахлагч сая ерөнхийд нь гол юмыг нь хариулчихлаа, тэгээд мэдээлэл хариуцагчтай холбоотой би сая Цэрэнпунцаг гишүүний асуултад хариулъя.

Мэдээж мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах гэдэг зүйл байгаа юм. Мэдээлэл хариуцагчийг үүрэгжүүлж өгсөн байгаа юм. Нэг талдаа, ер нь яг энэ таны яг хэлж байгаа гол зүйлүүдийг л зохицуулахаар энэ хуулийн үзэл баримтлал нь оршиж байгаа юм. Ер нь төрийн мэдээллийг гурав ангилж байгаа. Нээлттэй хаалттай, хязгаартай гэж. Ямар мэдээллүүд нь хаалттай байх юм. Ямрыг нь мэдээллийн эзний зөвшөөрөлтэйгөөр бусдад түгээх юм. Ашиглуулах юм ямрыг нь нээлттэй байлгах юм гээд.

Тэгэхээр мэдээллийн эзний өөрийнх нь эрх гэдэг зүйлүүдийг 11 эрхийг энд суулгаж өгсөн байгаа. Мөн мэдээлэл хариуцагчийг үүрэгжүүлж өгсөн байгаа. Жишээ

нь 18.2.3 дээр мэдээллийн эзнээс зөвшөөрөл авахдаа энэ хуулийн 8.2-т заасан мэдээллээр хангах, мэдээлэл цуглуулж байгаа зорилго, үндэслэлийг мэдээллийн эзэнд ойлгомжтой, тодорхой тайлбарлах гэж хэлж өгсөн байгаа. Тэгэхээр 8.2 нь маань өөрөө мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах, яг ямар ямар мэдээллийг ямар нөхцөлөөр одоо танилцуулж зөвшөөрөл авах юм бэ гээд энэ дээр 7 төрлийн мэдээллийг заавал мэдээллийн эзэнд одоо ойлгомжтой байдлаар тайлж бичиж зөвшөөрөл.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ дараа Учрал гишүүн хариулна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Би хоёр, гурван зүйл асуугаад орхиё.

Нэгдүгээрт энэ 12 дугаар зүйл сэтгүүл зүйн зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах 12.2 дугаар заалт нь мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр, эмзэг мэдээллийн багт ангилалд багтаасан, захидал харилцаа, нийтийн ашиг сонирхол хамгаалах зорилгоор ашиглалт болохгүй гээд ингээд заачихсан байгаа юм. Гэтэл энэ захидал харилцаа ил болгосноор олон гэмт хэрэг илчлэгдэж байгаа. Үүний тодорхой жишээ бол сноуден, тусгай байгууллага, улс төрчдийн хувийн захидлаас олж нийтэлсэн мэдээллийн ачаар олон олон хууль бус үйл ажиллагаа ил боллоо шүү дээ. Дэлхий нийтээрээ. Манай улсын хувьд ч сэтгүүлчид маань төрийн хөрөнгө завшиж хууль бусаар гэнэт бичсэн этгээдүүдийн талаар мэдээллийг хувийн захидал харилцааны, ялангуяа энэ цахим захидал, харилцааны нууцаас ил болгож энүүгээр одоо Улсын Ерөнхий сайдаас эхлээд Засгийн газарт ажиллаж байсан улс төрийн нөлөө бүхий этгээдүүд ял авлаа шүү дээ.

Үгүй ээ, тэгээд энийг одоо ингээд таг хаагаад авахаараа зэрэг энэ чинь одоо яах юм, болж байна. Энэ шинэ хуулиар сэтгүүлчид энэ мэдээллийн эх сурвалжийг ашиглаж болохгүй гэж ингэж ойлгож болох уу? Энэ дээр нэг тодорхой хариулт өгөх бололцоо байна уу гэж. Түрүүн тэр дуу дүрсний, дуу дүрсний бичлэгийн систем гээд энэ 27 дугаар зүйл байгаа юм. Энэ системийг хаана ямар тохиолдолд ашиглаж болох вэ? Ямар тохиолдолд ашиглахыг хориглох талаар тодорхой заасан. Гэхдээ энд одоо ердийн бус нөхцөл байдал бол байнга үүснэ ээ. Тухайлбал тэмцээн уралдаан зохион байгуулагддаг ч юм уу, эсвэл одоо алслагдсан бүс нутгууд цэргийн анги, байгууллага хил хамгаалалт, цаашлах юм тусгай хамгаалалтад зайлшгүй байх ёстой банк, даатгалын компани ч гэдэг юм уу. Тэгээд энд одоо тухайлах юм бол гэмт хэрэг зөрчил гарах, иргэдийн амь бие цаашилбал эд хөрөнгө хохирох ийм асуудал гарвал энэ зөрчлийг ер нь яаж зохицуулахаар одоо зохион байгуулсан байна. Энэ хуульд одоо тодорхой зохицуулалтууд байна уу гэж.

Цаашлах юм бол хүн, хуулийн этгээдийн мэдээлэл цуглуулах, боловсруулах ашиглахтай холбоотой 7 дугаар зүйл байгаа юм. Ялангуяа одоо энэ ажил олгогчтой холбоотой хүмүүсийн, нууцын зэрэглэлийн энэ мэдээллүүдийг авснаар тухайлбал одоо ажил олгогч тухайн хүнийг ажлын байраар хангах ч байдаг юм уу, энэ харилцаан дээр ямар нэгэн хүндрэл асуудлууд гарах уу? Түрүүн 10 дугаар зүйлтэй холбоотой энэ биометрик болон генетик мэдээллийг цуглуулах, боловсруулах ашиглахтай холбоотой асуудлаар Тэмүүлэн гишүүн тодорхой асуулт асуугаад энүүгээр нэлээн мэтгэлцээн болчихсон учраас би энэ асуултыг орхиё.

Баярлалаа.

Н.Учрал: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Тэр 7 дугаар зүйл дээр хүн, хуулийн этгээд, хуулийн этгээд эрх бүхий байгууллага мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах гээд төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага дараах тохиолдолд мэдээлэл цуглуулж боловсруулж, ашиглаж болно гэсэн заалт байгаа юм.

Энэ юу вэ гэхээр төрийн байгууллага ямар тохиолдолд мэдээллийг цуглуулж боловсруулах вэ гээд 6 дугаар зүйл дээр мэдээллийн эзний зөвшөөрлөөр хуульд заасан үндэслэлээр хуульд заасан тохиолдолд хөдөлмөрийн харилцааны явцад мэдээлэл хариуцуулж эрхээ эдлэх үүргээ биелүүлэх гээд ингээд 6.1.6-аас дараах тохиолдлууд гэж 6 тохиолдлыг бичсэн. Мөн нийтийн мэдээллийн хуулийг бас энэ үед хэлэлцэж байгаа. Нийтийн мэдээллийн хуулиар төрийн байгууллагуудын 5 багт 67 мэдээллийг нээлттэй болгож байгаа.

Тэгэхээр тэр нийтэд нээлттэй болгож байгаа мэдээллийг бол боловсруулж цуглуулж ашиглахыг нээлттэй. Хаалттай мэдээллүүд бусад одоо тохиолдлуудыг бол энэ тохиолдолд боловсруулж ашиглаж болохгүй гэдгийг нь 6, 7 дугаар зүйл дээр тодорхой зааж өгсөн байгаа шүү гэдгийг хэлье. Тэр 67 мэдээллийн хувьд бол хуулиар өөрөө нээгдэж байгаа учраас чөлөөтэй мэдээлэл цуглуулж ашиглаж болно. Бусад тохиолдлуудыг нь заасан.

Хоёрдугаар асуулт дээр хариулахад. 12 дугаар зүйл буюу сэтгүүл зүйн зорилгоор мэдээлэл цуглуулж, боловсруулж ашиглах асуудал дээр бас сэтгүүлчид буруу ойлголттой яваад байсан. Тэгэхээр энэ бол 12.1 дүгээр заалт бол сэтгүүл зүйн зорилгоор эсхүл нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс мэдээллийг цуглуулж боловсруулж ашиглаж болно гэсэн заалт болж байгаа буюу одоо энэ зарчмын зөрүүтэй саналаар мэдээллийн эзний зөвшөөрлөөр гэдэг үгийг хасаж байгаа. Тэгэхээр сэтгүүлчид бол мэдээж нотлох баримттайгаар эх сурвалжтайгаар сэтгүүл зүйн зорилгоор эсвэл нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс мэдээллийг цуглуулж боловсруулж ашиглахдаа заавал мэдээллийн эзний зөвшөөрлийг шаардахгүй.

Харин 12.2 дээр буюу мэдээллийн эзний зөвшөөрөлгүйгээр сэтгүүлчид ч байсан хүний эрүүл мэндийн мэдээлэл, захидал харилцаа, генетик, биометрик мэдээллийг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг зөвшөөрөлгүйгээр ашиглахыг бол бүтэн хориглож байгаа. Тэгэхээр энэ нь юу вэ гэхээр хүний эмзэг мэдээлэлд хамаарна. Хүний эмзэг мэдээлэлд.

Тэгэхээр сая Бат-Эрдэнэ гишүүний хэлдгээр захидал харилцаа бол одоо хүний хувийн мэдээлэл мөн. Тэгэхээр захидал харилцаа буюу 2 иргэн хоорондоо харилцсан тэр одоо мессенжер ч байдаг юм уу, бусад одоо мессежээр харилцсан захидал харилцааны нууцыг ил болгоод эзэн зөвшөөрөөгүй байхад олон нийтэд сэтгүүл зүйн зорилгоор ч байсан гаргаж тавихыг хуулиар хориглож байгаа.

Энэ бол одоо хүний эмзэг мэдээлэлд хамаарах асуудал юм гэдэг утгаар нь 12.2 дээр. Энэ мэдээллээс бусад мэдээллийг бол сэтгүүлчид нотлох баримттайгаар олон нийтэд гаргах сэтгүүл зүйн зорилгоор нийтлэхийг бол зөвшөөрнө.

Тэгэхдээ энэ тохиолдолд эсвэл нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс зорилгыг агуулж байх ёстой гэдэг утгаар нь энэ 12 дугаар зүйлийг оруулж өгсөн. Тэгээд мэдээж өмнөх хэлэлцэх эсэх асуудал дээр гишүүдийн зүгээс санал гарч байсан учраас бид энэ мэдээллийн эзний зөвшөөрлөөр гэдэг үгийг хасаж байгаа.

Энийг хассанаараа шууд утгаараа сэтгүүл зүйн зорилгоор нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс мэдээлэл цуглуулж боловсруулж ашиглаж болно гэдэг үг нээгдээд 12.1 дэх энэ заалт нь бол тодорхой энэ тохиолдлуудад хориглогдох байдлаар 12.2 дээр хуульчилж өгсөн.

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асууя. Тодруулж асууна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ажлын хэсгийн ахлагч Учрал гишүүнд. Тэгэхээр энэ юугаа сайн мухарлахгүй бол та сая хариулт дээр би авлаа. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой энэ мэдээллийг бол хэрхэвч нууцалж байж болохгүй ээ. Энэ сэтгүүлчид бол энийгээ чөлөөтэй авч олон нийтэд дэлгэдэг энэ мэдээллийнхээ нотолгоо, баримт, хариуцлагыг нь одоо бас давхар мэдээж үүрнэ. Энэнд нь тодорхой асуудал, тэр хувийн асуудал биш шүү дээ. Нийтийн эрх ашигтай холбоотой. Нөгөө авлига, ашиг сонирхол, хөрөнгө мөнгө дэлсдэг зувчуулдаг оффшорт аваачиж хийдэг, гадаадад өчнөөн байр сав авдаг ийм асуудлуудтай холбоотой л асуудал байгаа шүү дээ. Одоо энэ Их Хурал дээр нэг хууль орж ирэх гээд байгаа. Тэр нь бол улс төрчдийг гүтгэсэн бол ямар нэгэн байдлаар асуудлыг тавьж болохгүй гэдэг нэг ийм хууль яриад байгаа юм.

Энэ бол хэрхэвч байж болохгүй.

Г.Занданшатар: Энхболд гишүүн ээ, таны нэр нөгөө юу? Картаа ахиж одоо ороод ирлээ.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Их баярлалаа. Тэгээд энэ бол хэрхэвч байж болмооргүй энэ мэдээллийг сэтгүүл зүйн зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах ашиглахтай холбоотой юман дээр энийг бол тодорхой нээж өгөөд тавихгүй бол одоо манайд чинь нэг сайхан үг гарсан байна шүү дээ. Намайг гүтгэх эрхийг эрх чөлөөг чамд олгосон гэж хэлээд энэнийхээ араар ороод нуугдчихдаг. Тэгээд ерөөсөө бүх юмаа өө намайг гүтгэсэн, одоо гүтгэсэн ч гэсэн би энэ асуудлыг одоо тавих эрх байхгүй. Хуулиар хаачихсан гэдэг ийм юмны ар руу орох гээд байгаа учраас ингэж одоо болохгүй ийм зүйл байгаа юм аа. Тийм учраас энэ 12 дугаар зүйл дээр энэ оруулж ирэх гээд байгаа хуулийн бэлтгэлийг хангасан ийм санаа зүйл заалтууд байх вэ гэдэг энэ асуудлыг би хэлээд байгаа юм.

Ер нь ялангуяа энэ дээхэн талд байж байгаа төрийн өндөр ажил, албан тушаал, энэ хариуцлага үүрч байгаа улсууд аливаа хэл аманд одоо холбогдсон байх юм бол энийгээ баталгаа нотолгоотой нь мухарладаг олон түмэн.../минут дуусав/.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал гишүүн.

Н.Учрал: Сэтгүүл зүйн зорилгоор, эсвэл нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс мэдээллийг цуглуулж, боловсруулж ашиглаж болохыг нээж өгч байгаа 12.1-ээр. Тэгэхээр сэтгүүлчид тэр нотлох баримттайгаар нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс ямар нэгэн нийтлэл бичих мэдээ бичих бол чөлөөтэй. Гэхдээ хүний эмзэг мэдээлэл гээд энэ хуульд тодорхойлж өгсөн. Хүний эмзэг мэдээлэл дотор бол тэр эрүүл мэндийн асуудал бол эмзэг мэдээлэлд хамаарна шүү.

Захидал харилцаа, генетик биометрийн мэдээлэл бол эмзэг мэдээлэлд хамаарна. Бэлгийн болон хүйсийн чиг баримжаа илэрхийлэл бол хүний эмзэг мэдээлэлд хамаарах буюу энийг хувь хүний нууцад хамааруулж үзэж байгаа юм. Тэгэхээр эдгээр мэдээллийг бол мэдээллийн эзэн зөвшөөрөөгүй байхад ч сэтгүүл зүйн зорилгоор байсан ч олон нийтэд түгээхийг хориглох ёстой гэдэг утгаараа ингэж оруулж байгаа. Энэнээс бусад тохиолдолд бол тэр нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс бол мэдээллийг түгээх нээлттэй.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Нямаагийн Энхболд гишүүн.

Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Энэ орчин үеийн дэвшилт технологиудыг хэрэглэх болсонтой холбогдуулж түүний зохицуулсан нь хууль дүрэм хангалтгүй байгаа учраас олон нийтийн мэдэх эрх, хувийн нууцтай байх эрхийн асуудалд томоохон эрсдэл дагуулж байгаа нь үнэн юм.

Гурван асуулт байна.

Нэгдүгээрт нь энэ мэдээллийн системээс хувь хүний хувийн мэдээллийг хувийн байгууллагад шилжүүлэх, хувь хүний биометрик мэдээллийг төрийн байгууллагаас хувийн хэвшлийн байгууллагатай солилцох харилцааг бүрэн зохицуулаагүй байна гэсэн асуулт байна. Энэ дээр одоо хариулт өгөөч? Биометрик мэдээллийг иргэний зөвшөөрлөөр бусдад түгээх хуваалцах байдлаар иргэний хувийн асуудалд халдашгүй байх эрхийг зөрчиж байгаа нөхцөл байдал хэвээр үлдсэн гэсэн ийм бас асуулт байна

Хоёрдугаарт нь мэдээллийг устгуулах хувь хүнийг одоо мартагдах эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан боловч ямар ч тохиолдолд мэдээллийн эзэн өөрийн хувийн мэдээллийг хүсэлт гаргах замаар устгуулах эрхийг хуулийн төслөөр баталгаажуулаагүй байна гэж үзэж байна.

Энэ дээр хариулт авъя. Хуулийн төсөлд гэр бүлийн гишүүн хамтран амьдрагчид нэгнийхээ хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах тохиолдолд тус хууль үйлчлэхгүй байхаар заасан нь хүний халдашгүй байх эрхийг бүрэн хамгаалаагүй байна гэсэн ийм асуулт байна. Энэ эдгээр асуултад хариулт авна.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал гишүүн ажлын хэсгийн даргын Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга.

Н.Учрал: Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Өмнөх асуултад бас хариулсан. 10 дугаар зүйл дээр тэр биометрик болон генетик мэдээллийг цуглуулж, боловсруулж ашиглах буюу төрийн байгууллага зөвхөн дараах таван тохиолдолд л биометрик генетик мэдээллийг боловсруулж ашиглана гэсэн заалт байгаа. Тэгэхээр энэ хуулиар бол одоо хувийн байгууллагууд мөн хүнсний бараа бүтээгдэхүүн зарж байгаа худалдаа үйлчилгээний төвүүд ч гэдэг юм уу, янз бүрийн одоо дэлгүүрүүд, хүний хурууны хээгээр бүртгэл аваад тэгээд түүнийгээ боловсруулаад судалгаанд оруулаад ингээд харилцаад байдаг ийм замбараагүй байдал бол байсан. Тэгэхээр энэ хуулиар бол энэ хүний дахин давтагдашгүй өгөгдөл биометрик мэдээллийг цуглуулахыг дараах зөвхөн төрийн байгууллагын нөгөө бүртгэл, хил хамгаалах, нөгөө шүүхийн шинжилгээний байгууллага гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор гэсэн тохиолдлуудаас бусад тохиолдолд хүний давтагдашгүй өгөгдлийг цуглуулахыг бүрэн хориглож байгаа гэсэн үг.

Тэгэхээр одоо хувийн байгууллагууд одоо тэр хурууны хээгээр нь бүртгэл авдаг, одоо цагийн ирцийн мэдээллүүдээ авдаг энэ байдал бол энэ хуулиар одоо бүрэн зогсоно. Тэгэхээр зөвхөн энэ тохиолдлуудаас бусад тохиолдолд бол хүний энэ эмзэг мэдээллийг цуглуулахыг бүрэн хориглоно. Тэгэхээр мэдээж энэ бол үүний дараа маш олон дэвшлүүд бол гарна. Тэгэхээр энэ зохион байгуулалтгүй замбараагүй байдал бол бас арилна гэдгийг бас хэлмээр байна.

Г.Занданшатар: Пүрэвжавын Сайнзориг, Хууль зүйн бодлогын газрын дарга, Хууль зүйн яамны. 83.

П.Сайнзориг: Баттөмөр гишүүний сүүлийн асуултад хариулъя. Тэр хамтран амьдрагчийн асуудлыг одоо яагаад хуулийн үйлчлэх хүрээнд оруулж ирээгүй юм бэ, энэ хамтран амьдрагч бие биеийнхээ мэдээллийг бас дур зоргоороо цуглуулаад боловсруулаад ашиглах уу гэдэг асуудал байгаа. Энэ дээрээс бас Хууль зүйн байнгын хороон дээр бас энэ хуулийн төслийг хэлэлцэх явцад нэр бүхий гишүүдээс санал гаргаад хамтран амьдрагч гэдгийг нь хассан байж байгаа.

Гэхдээ хуулийн томъёолол маань бол хамтран амьдрагчийг, бас бие биеийнхээ тэр халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчихгүйгээр цуглуулж болно л гэж байгаа юм. Өнөөдөр бол практик дээр бол магадгүй дундаасаа хүүхэдтэй гэр бүлээ батлуулаагүй боловч хамтран амьдарч байгаа тохиолдлууд бол зөндөө байдаг. Тэгэхээр яах вэ? Энэ тохиолдлуудыг бол бид нар бол энэ хуулийн үйлчлэлд заавал оруулаад яах вэ гэсэн. Энэ дээр бол Хууль зүйн байнгын хороон дээр саналын томъёолол орж ирээд одоо таны дараагийн саналын томъёоллууд хураагдахад энэ хамтран амьдрагч гэдэг заалт бол хасагдаж байгаа гэдэг зүйлийг бас танд хэлье ээ.

Г.Занданшатар: Тийм нэгдүгээр санал хураалтаар хасагдаж байсан.

Эрхэм гишүүн Нямаагийн Энхболд.

Н.Энхболд: Баярлалаа, гурван асуулт байна. Энэ Үндсэн хуулийн 16.13-т хувь хүний, хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууцыг одоо илрүүлж, задалж болохгүй ээ гээд ингээд заачихсан байж байгаа. Яг хувь хүний нууц гэж яг юу хэлэх юм тэр эмзэг сэдвээс. Эмзэг гээд байгаа юм эрүүл мэндээс бусад тэрийг нь хэн тодорхойлох юм бэ гэдэг дээр энэ хуульд тусгайлан тодорхойлсон зүйл байна уу, нэгдүгээрт.

Хоёрдугаарт бас Үндсэн хуульд байгаа. Аливаа хүнийг эрхэлсэн албан тушаал нь ялгаварлан гадуурхаж болохгүй ээ гэсэн. Тэгэхээр иргэн, албан тушаалтан хоёрын нууцтай холбогдолтой зүйлийг ялгаж салгасан. Өөрөөр хэлбэл ялгаварласан тийм заалт байна уу төрийн өндөр албан тушаалтан чиний юмыг ил тавьж байх ёстой гэж заасан. Тийм утга агуулгатай заалт байгаа бол тэр чинь энэ Үндсэн хуулийн 14.2-т байгаа эрхэлсэн албан тушаал нь ялгарч болохгүй гэдэгтэй зөрчилдөх үү? Хоёр дахь асуулт.

Гурав дахь нь, ер нь манайд нэг үзэгдэл ийм газар аваад байгаа. Улс төрийн зорилгоор аливаа гэмт хэргийг одоо мөрдөж шалгах, байцаах явцад олсон мэдээллээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр сошиал орчноор урд нь баахан цацаад, тэр хүнийг нийгмээр яллуулаад уур амьсгал бий болгоод шүүгч нарт нөлөөлөөд хууль хяналтын байгууллагад нөлөөлөөд, тэгээд эргээд шийтгэдэг. Бодлогоор юм явуулдаг.

Тэгэхээр ийм юм хийж байгаа хүмүүсийг Нэгдүгээрт тэр хуулиар хориглогдсон мөрдөн байцаах, шалгах явцад явж байгаа юмыг гаргаж болохгүй гээд хуультай.

Хоёрдугаарт энэ чинь бас дандаа хувь хүнтэй холбоотой нууцууд байж байгаа. Энэ зүйлүүдийн талаар яг энэ хуульд туссан зүйл байна уу, эсвэл эс үгүй бол бусад хуулиараа зохицуулаад явна гэж бодож байгаа юу? Хувь хүний нууц гэдэгтэй нь холбоотойгоор. Энэ чинь Үндсэн хуулийн 16.4-т бас байж байгаа шүү дээ. Шүүхээр гэм буруутай нь нотлоогүй бол тэр хүнийг гэм буруутайд тооцохгүй ээ гээд Үндсэн хуулиар. Үндсэн хуулийн энэ 14.2, 16.4-т заасан энэнээс давсан ийм заалт, зохицуулалт энэ хуулийн төсөлд чинь орсон уу?

Маш тодорхой хариулт өгөхийг хүсье ээ. Гурван ийм асуулт байна.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал гишүүн.

Н.Учрал: Хувь хүний нууцын хууль буюу энэ өмнөх хуулиар хүний мэдээллийг яг ингэж хувийн, хувь хүний эмзэг мэдээлэл гэж ангилаад, одоо энэ хуульд заасан шиг тодорхой бол заагаагүй байсан байна. Тэгэхээр одоо энэ хуульд хүний эмзэг мэдээлэл гэдэгт гээд тоочиж бол заасан. Одоо хүний үндэс угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, биометрик, генетик, цахим гарын үсгийн, хувийн түлхүүр ял эдэлсэн эсэх, ял эдэлж байгаа эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжааны мэдээллийг гэж. Тэгэхээр энэ хүний эмзэг мэдээллийг хувь хүний нууцад хамааруулна гэж энэ хуульд зааж байгаа юм. Тэгэхээр эдгээр мэдээллүүдийг бол шууд хувь хүний нууцад хамааруулж авч үзэж байна гэсэн үг.

Мэдээллийг дотор нь ангилаад тэгээд хоёр дахь асуулт дээр бол тэр нөгөө төрийн өндөр албан тушаалтнуудыг гэж тийм ялгасан ч юм уу зохицуулалт байна уу гэж байгаа. Тэрэн дээр бол тийм зүйл байхгүй. Гэхдээ бид өмнө нь хүний эмзэг мэдээлэл дээр нөгөө хөрөнгө гэдэг мэдээллийг оруулчхаад яваад байсан. Хувь хүнийг нууцаар хамгаална гээд. Гэтэл одоо нөгөө Авлигатай тэмцэх газар хуулийнхаа дагуу төрийн албан тушаалтнууд өөрсдийнхөө нөгөө хөрөнгө орлогын мэдүүлгийг ингээд мэдүүлдэг. Энэ нь олон нийтэд ил болдог. Тэгэхээр энэ олон нийтэд ил болоод байгаа учраас энийг эмзэг мэдээлэлд хамааруулчих бол хуулиуд хоорондоо зөрчилдөнө. Тийм учраас энэ хөрөнгийн талаарх мэдээллийг бол хүний

хувийн мэдээлэл рүү оруулахаар энэ зарчмын зөрүүтэй саналуудаар оруулж ирж байгаа юм. Тэгэхээр хөрөнгийн мэдээлэл бол нөгөө Авлигатай тэмцэх газар мэдүүлээд ил болж байгаа учраас ингээд ялгаад өгнө.

Тэгэхээр хүний эмзэг мэдээлэлд үлдсэн бусад одоо саяын хэлсэн мэдээллүүд бол хувь хүний нууцаар шууд хамгаалагдана.

Хариуцлагын хувьд бол энэ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэх, дагаж мөрдөх хууль бол бас дагаж орж ирж байгаа. Мөн одоо дагаж мөрдөх хууль дотор бол нөгөө Эрүүгийн хуулиар буюу Хувь хүний хуулиар хамгаалагдсан, саяын одоо нууцад хамаарах мэдээллийг хууль бусаар олж авсан. Эсвэл бусдад дамжуулсан бол мөн торгох, зорчих эрхийг хязгаарлах ялтай. Мөн 13.11 дээр бас хорих ялаар шийтгэх гээд ингээд сонгох санкцтайгаар ингээд орж ирж байгаа юм.

Тэгэхээр энэ заалт болгон дээр жишээ нь тэр хувь хүний эрүүл мэнд, захидал харилцааны талаарх мэдээлэлд халдах асуудлаар 13.12 дээр болохоор нөгөө бэлгийн харьцааны бэлгийн чиг баримжаа илэрхийллийн талаар задруулсан бол гээд ангилалтайгаар Эрүүгийн хууль дээр бас ийм сонгох санкцтайгаар оруулж ирж байгаа учраас мэдээлэл цуглуулж боловсруулж байгаа тал бол үүн дээр хариуцлага хүлээнэ гэсэн үг.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд гишүүн тодруулж асууя.

Н.Энхболд: Би хамгийн сүүлд их тодорхой зүйл асуусан. Шүүхээр нотлогдох хүртэл хэн ч гэм буруутайд тооцогдохгүй ээ гэж. Гэтэл энэ мөрдөн байцаах шалгах ажиллагааны явцад олж авсан мэдээллээ олон нийтэд цацаад байгааг юу гэж үзэх вэ. Энэ хувь хүний нууцыг задруулаад байна гэж үзэх үү, эс үгүй бол албан тушаалын гэмт хэрэг гэж үзэх үү? Энүүнийг тодорхой заасан юм байна уу? Энэ чинь одоо хэрэгсэл болчхоод байна шүү дээ. Газар авчхаад байна.

Улс төрчид улс төрийнхөн бие биеийгээ, намнадаг хэрэгсэл болчхоод байна. Энэ чинь ямар нэг байдлаар хувь хүний нөөцтэй холбоотой юмнууд энэ дотор байж л байгаа. Тэрийг нь нуугаад хаагаад бай гэсэн үг биш л дээ. Шалгаад үзээд яваад хуулиар, шүүхээр нөгөөдөх нь нотлогдоод ирвэл тэр хүн тэртээ тэргүй ялаа хүлээнэ. Ганцхан ийм уур амьсгал бүрдүүлээд байгаа. Ингэж бусад хуулиар хориглочихсон зөрчөөд байгаа улсуудыг яах юм бэ гэж байна.

Г.Занданшатар: Барсүрэнгийн Баасандорж Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга. 81.

Б.Баасандорж: Энхболд гишүүний асуултад хариулъя аа, Баасандорж. Энэ Хүний хувийн мэдээллийн тухай хууль хэлэлцсэний дараа Нийтийн мэдээллийн тухай хуулийг хэлэлцэнэ. За яг энэ Нийтийн мэдээллийн тухай хууль дээр бол саяын Нямаагийн Энхболд гишүүний асуусан зохицуулалтыг бол нэлээн тодорхой зохицуулж өгсөн байгаа. Өөрөөр хэлбэл, энэ Нийтийн мэдээллийн тухай хууль дээр хязгаарлалтай мэдээлэл гэж тодорхойлж өгсөн. Энэ хязгаарлалтай мэдээллийг нэгт бол тухайн иргэний зөвшөөрөлтэйгөөр мэдээлнэ. Хоёрт эрх бүхий албан тушаалтан. Өөрөөр хэлбэл нөгөө шүүгч, прокурорын зөвшөөрөлтэйгөөр одоо мэдээлэх асуудал байгаа. Тэгэхээр энэ 9.2 дээр одоо хүн, хуулийн этгээдэд

хамаарах хязгаартай мэдээлэл дараах мэдээлэл хамаарна. Хуульд өөрөөр заагаагүй бол гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад цуглуулсан мэдээлэл.

Тэгэхээр энэ мэдээлэл нь өөрөө хязгаарлалттай мэдээлэл. Хамаагүй цацахгүй. Хэрвээ тухайн албан тушаалтан Баасандорж прокурорын зөвшөөрөлгүй цацах юм бол би өөрөө хуулийн хариуцлага хүлээнэ. Энийг бол өөрөө тухайн иргэний зөвшөөрөлтэйгөөр л цацаж болно. Ийм зүйл байгаа.

Та мөн гүйцэтгэх ажлын тухай холбоотой асуулт асуусан. Саналын томьёоллын хоёр дахь хэсэг дээр Гүйцэтгэх ажлын тухай хуулиар тусгайлан.

Г.Занданшатар: Гүйцээж хариулъя. 81.

Б.Баасандорж: Гүйцэтгэх ажлын тухай хуулиар тусгайлан зохицуулснаас бусад харилцааг бол энэ хувь хүний нууцтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахаар хийчихсэн байгаа. Энэ саналын томьёоллын хоёр дээр орж байгаа юм. Та бас яг Үндсэн хууль дээр зохицуулсан нөгөө хувь хүний нууцыг хуулиар хамгаална гэж Үндсэн хууль дээр зааж өгсөн байгаа. Тэгэхээр энэ хуулийн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль дээр яг энэ Үндсэн хуулиар заасан зохицуулалтаа бататгах үүднээс 9.1 дээр энэ хуулийн 4.1.2-т заасан эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн, хувийн түлхүүр, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх хүний эмзэг мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарна гээд хуульчилж өгсөн байгаа. Захидал харилцаа хамаарч байгаа. Энд захидал харилцаа гээд байгаа.

Захидал харилцаа өөрөө хаалттай мэдээлэлд орж байгаа. Энэ 9.1 дээр захидал харилцаа орсон байгаа.

Г.Занданшатар: Үндсэн хуульд хувийн, гэр бүлийн, захидал харилцааны нууцыг хуулиар хамгаална гэж байгаа юм.

Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Санал хураалт явуулахад өдрийн завсарлага болсон учраас бас хангалтгүй байна. Учрал гишүүн ээ, Баасандорж дарга аа, ер нь олон улсын жишиг, чиг хандлага бол ямар ч мэдээлэл байлаа гэсэн одоо нэг талын баримт байж болно шүү дээ. Хувь хүн хүн алчихсан юм аа гээд. Яагаад гэхээр эртний ромын шүүхийн зарчим дээр тэгж бичсэн байдаг нь бол зам дээр одоо хутгалуулаад үхчихсэн хүн хэвтэж байхад хажууд нь хутгыг нь барьчихсан цус болчихсон хүн зогсож байлаа ч гэсэн тэрийг гэм буруутай гэж үзэж шууд үзэхгүй ээ. Өөрөөр хэлбэл тэр хүн аврах гээд хутгыг нь сугалаад бариад зогсож байсан байж болно шүү дээ гэж.

Ийм учраас нотлох цагаатгах баримт хоёрыг хоёуланг нь заавал тэнцүү баримтлах ёстой гэсэн ийм зарчим бүх одоо шүүхийн болон хэвлэл мэдээллийн бүх зарчимд үйлчилдэг. Тэгэхээр нэг хүний талаар бичих бол ийм баримт ирлээ. Энэ дээр та өөрөө өөрийгөө хамгаалах ёстой нөгөө Үндсэн хуулийн бүх мэдээллийн нууцлалаас гадна нэр төр, эрхэм нандин байх чанар бол сэтгүүлч байлаа гэсэн энэ хүнийг бичиж болно. Улс төрч хүн хэнийг ч бичиж болно, тэр нь нээлттэй байх хэрэгтэй. Гэхдээ нөгөө талаас өөрөөс нь заавал няцаалт авдаг байгаа хэрэгтэй.

Одоо CNN ч байдаг юм уу, дэлхийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг хараарай сонин хэвлэл. Энд нь тэр хүний талаар мэдээлэл тавьж байгаа бол заавал тэр хүнээс няцаалт авсан байх. Хэрвээ няцаалт өөрөөс нь аваагүй бол өөрийгөө хамгаалах эрхийг нь өгөөд боломжийг нь өгөөгүй бол энийг нэг талыг барьсан мэдээлэл, гүтгэлэг гэж үздэг.

Тийм учраас тэнцүү мэдээлэл заавал тэнцүү сонины зай, телевизийн цаг, радиогийн цаг ч бай тэнцүү боломжийг нь олгож байдаг. Энэ бол ингээд нөгөө хүний эрхийн чинь үндсэн суурь зарчим нь. Мэдээж энэ талын мэдээлэл бол мэдээлэх эрхийг бол сэтгүүлчдэд хааж боох бололцоогүй. Нөгөө талдаа тэр хүн тэнцвэртэй мэдээлэл, ард иргэдийн мэдэх эрхийг хангахын тулд аль алийг нь буруутгах болон цагаатгах зөвтгөх баримтыг тэнцүү танилцуулах нь сэтгүүлчийн, мөрдөх байгууллагын хуулийн, шүүхийн хүний эрхийн ардчилсан Үндсэн хуулийн суурь зарчим байхгүй юу. Энийг энэ хуулийнхаа концепц дээр бас оруулж өгч, бусад хууль дээрээ та нар бас анхаарч байвал сайн байгаа юм. Энэ бол энэ нэлээд тунхаглалын ч гэсэн суурь зарчим. Юугаа ч мэдэхгүй явж байхад нь нэг хүнийг маргааш нь алуурчин гэмт хэрэгтэн юу ч гэдэг юм ингээд чичдэг. Өөрийгөө хамгаалах, эрхээ хамгаалах нэр төрөө хамгаалах эрхийг нь өгөхгүй байна гэдэг бол өөрөө зөрчил. Энэ суурь зарчмыг бий болгомоор байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолол 46 санал байгаа. Ингээд үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан завсарлаж байна. Яг 14 цагт гишүүд бүрэн ирцтэйгээр цуглаарай. Санал хураалт явагдах учраас яг 14 цагаас хурал үргэлжилнэ.

ЗАВСАРЛАГА

Г.Занданшатар: Гишүүдээ Улсын Их Хурлын намрын чуулганы 11 дүгээр сарын 11-ний өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Одоо санал хураалт явуулах учраас гишүүд чуулганы танхимдаа цуглацгаана уу. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байгаа.

Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар гарсан зарчмын зөрүүтэй 46 санал байгаа. 14 цагаас Ардчилсан намын бүлгийн авсан завсарлагын хугацаа Төсвийн хууль, дагалдах хуулиудын хамт Нийгмийн даатгалын сангийн, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиудад үргэлжлүүлж хэлэлцэнэ. Санал хураалт явуулъя.

Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн.

Д.Тогтохсүрэн: Тэгэхээр миний горимын санал одоо хэлэлцэж байгаа хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг хийгдэж байгаа. Энэ хуулийнхаа төслийг хойшлуулаад төсвийн тухай хуулиа хэлэлцэх ийм горимын санал гаргаж байгаа юм.

Бид төсвийн хуулиа маргаашийн дотор багтааж төсвөө хэлэлцэж батлах ёстой. Өглөө Төсвийн хүрээний мэдэгдэл дагасан хуулиуд болон бусад хууль тогтоомжуудаар эцсийн хэлэлцүүлэг хийгдсэн. Өнөөдөр 3 дугаар хэлэлцүүлэг хийгдээд маргааш 4 хэлэлцүүлгээр ингээд бэлэн болох ёстой учраас дээр нь Ардчилсан намын завсарлагын хугацаа дууссан байна. Тийм учраас энэ хэлэлцэж байгаа хуулийн төслийг түр хойшлуулж оронд нь Төсвийн тухай хуулийг хэлэлцэж 3 дугаар хэлэлцүүлгээ явуулчихаад үргэлжлээд энэ хувь хүний мэдээллийн хуулийг хэлэлцвэл яасан юм бэ гэсэн горимын санал гаргаж байгаа юм. Энэ горимын саналаар санал хураалгаж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал хураалт явуулна. Булгантуяа гишүүн суудалдаа сууя. Санал хураалт явуулна. Монгол Ардын намын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Хугацаатай асуудал болох Төсвийн хууль, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслөө хэлэлцье гэсэн горимын саналаар санал хураалт явуулна.

Санал хураалт. 28 гишүүн дэмжиж, 60.9 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. Ингээд хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийг хойшлууллаа.

Төсвийн тухай хуулийг хэлэлцэж эхэлье. Төсвийн хууль хэлэлцэж эхлэх болсонтой холбогдуулаад төсвийн хуулийн талаар завсарлага авсан байгаа Арчилсан намын бүлгээс.

Ардчилсан намын бүлгийн дарга Дашдондогийн Ганбат. Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Ганбат энэ асуудлаар 14 цаг хүртэл завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна.

Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулж Дашдондогийн Ганбат гишүүн үг хэлнэ.

Д.Ганбат: Яах вэ, Төсөв хуулийн хугацаатай энийг ойлгож байгаа. Тэгээд одоо маш богино хугацааны завсарлага дотор нэлээн хэдэн ажлыг амжууллаа. Төсвийн байнгын хорооны даргыг Тогтохсүрэн дарга орлож байгаа юм байна. Тэгээд олонхын бүлгийн даргатай санал солилцлоо. Ер нь тэгээд ч энэ цахим сүлжээнд мэдээлэл их хурдтай тархаж байна. Манай бүлгийн сайт руу, манай бүлгийн гишүүд рүү гаднаас олон хүн ярьж байна. Олон хүн коммент бичиж байна. Ер нь одоо энэ танай бүлгийн тавиад байгаа шаардлага тэр дөрвөн шаардлага маш зөв байна. Гадаа нөхцөл байдал бол үнэхээр хүнд байна шүү гэдэг зүйлийг хэлж байна. Тэгээд Ардчилсан намын бүлгээс завсарлага авсантайгаа холбогдуулаад цаашдаа санал гаргаж байна. Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулаад ажлын хэсэг байгуулъя. Ялангуяа одоо тэр инфляц, тэтгэвэр тэтгэмж, хувийн хэвшлийг дэмжих энэ ажлын байр, нөхцөл байдал одоо ковидын болон хил хад хаагдсантай холбогдуулаад олон аж ахуйн нэгж бол хаалгаа барьсан.

Одоо эдийн засгийг тэлэх, одоо орлого олох энэ талаар бас Их Хурал ажиллах ёстой гэсэн ийм бодолтой байна. Тэгээд манайхаас гаргаж байгаа, одоо ажлын хэсэг байгуулах саналыг одоо Их Хурлын дарга чиглэл өгөх үү, одоо дэмжих үү? Ямар ч байсан протоколд тусгуулъя аа.

Г.Занданшатар: Завсарлагын хугацаа дууссан учраас Төсвийн тухай хуулиа хэлэлцэнэ. Ардчилсан намын бүлгийн даргын гаргасан санаачилгаар Монгол Ардын намын бүлгийн дарга ч гэсэн ийм санаачилга бас гаргаж байгаа. Эдийн засгийг сэргээх асуудлаар ажлын хэсэг байгуулах, одоо төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих, хувийн хэвшлийг дэмжих, эдийн засгийг сэргээх энэ ковидын үед болон дараа нь асуудлаар одоо ажлын хэсэг байгуулж болно. Одоо ажлын хэсгүүд байгуулах саналаа бүлгийн дарга нар гишүүдийнхээ нэртэй өгөөд энэ ажил дээр ажиллаж болох юм.

Дараа дараагийнхаа бүлгийн хурлуудаар хэлэлцээд саналаа гаргаж болно оо.

Хүний хувийн мэдээллийн нууцыг хамгаалах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан үг хэлж дууссан. Одоо Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналыг нь томъёоллоор. Санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй 46 санал байгаа.

Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.3.1 дэх заалтын “гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагчид” гэснийг “гэр бүлийн гишүүнд” гэж, 3.3.2 дахь заалтын “гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагчийн” гэснийг “гэр бүлийн гишүүний” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Мөнх-Оргил.

Санал хураалт.

27 гишүүн дэмжиж, 57.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.4.Гүйцэтгэх ажлын тухай хуулиар тусгайлан зохицуулснаас бусад хувь хүний нууцтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулна.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Х.Нямбаатар, Ж.Сүхбаатар.

Санал хураалт.

58.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “иргэний бүртгэлийн дугаар,” гэсний дараа “хөрөнгө,” гэж нэмж, 4.1.6 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн “Иргэний хуулийн 16, 17, 18, 19 дүгээр зүйлд,” гэснийг “Иргэний хуулийн 17, 18, 19 дүгээр зүйлд хуульд өөрөөр заагаагүй бол мөн хуулийн 16 дугаар зүйлд” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 4.1.2, 4.1.3, 4.1.4, 4.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.2.“хүний эмзэг мэдээлэл” гэж хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг;

4.1.3.“мэдээлэл цуглуулах” гэж Нийтийн мэдээллийн тухай хуулийн 4.1.6-д заасныг;

4.1.4.“мэдээлэл боловсруулах” гэж Нийтийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасныг;

4.1.5.“мэдээлэл ашиглах” гэж Нийтийн мэдээллийн тухай хуулийн 4.1.4-т заасныг;” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал, Норовын Алтанхуяг, Пүрэв-Очирын Анужин, Энхтайваны Бат-Амгалан, Тогмидын Доржханд, Лхагвын Мөнхбаатар, Батсүхийн Саранчимэг, Жамъянхорлоогийн Сүхбаатар, Дамдины Цогтбаатар. Цаашид ажлын хэсэг гэнэ.

Түрүүн Нямаагийн Энхболд гишүүн захидал харилцаанд орчихсон уу. Энэнээс бусад нь ингээд тооччихоор хүний хувийн мэдээлэлд орохгүй юу. Амьдрал баян өөр мэдээлэл гарч ирвэл хувийн мэдээлэлд орохгүй гээд байх уу. Хувийн мэдээлэл гэж байгаа юм Үндсэн хуульд. Хувийн болон гэр бүлийн, захидал харилцааны мэдээллийг хуулиар хамгаална гэж байгаа. Үндсэн хуульд. 4.1.1 дээр хувийн мэдээллийг бүгдийг нь оруулчихсан уу. Эмзэг мэдээлэл гэж дахиж ялгаж байгаа юм уу. Хүний хувийн мэдээлэл хувийн нууц бол эмзэг мэдээлэл, эмзэг бус мэдээлэл гэж хоёр хувааж байгаа юм. Энийгээ Үндсэн хуульд нийцүүлж ингэж хянаж үзээрэй.

Санал хураалт.

Ингэж тоочхоор бусад мэдээлэл нь эмзэг бус мэдээлэл биш юм шиг ялгах. Хууль зүйн техникийн хувьд сөрөг үр дагавар гарч магадгүй шүү дээ. Энийгээ бусад Үндсэн хуулиар хамгаалсан бусад ч гэдэг юм уу.

30 гишүүн дэмжиж, 62.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “мэдээлэл хамгаалахад” санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

27 гишүүн дэмжиж? 57.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5. Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтын “утга зохиолын бүтээл туурвих,” гэсний дараа “нээлттэй өгөгдөл,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

26 гишүүн дэмжиж, 54.2 хувийн саналаар дэмжигдлээ

6.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “хуульд зааснаас бусад тохиолдолд” гэсний дараа “мэдээллийг боловсруулах, цуглуулах, ашиглахдаа” гэж, 8.2.3 дахь заалтын “боловсруулах,” гэсний өмнө “цуглуулах,” гэж тус тус нэмж, 8.2.6 дахь заалтын “мэдээллийн төрөл, агуулга” гэснийг “мэдээллийн жагсаалт” гэж, 8.2.7 дахь заалтын “цуцлах нөхцөл” гэснийг “цуцлах хэлбэр” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

27 гишүүн дэмжиж, 55.4 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.1.Энэ хуулийн 4.1.2-т заасан эрүүл мэнд, захидал харилцаа, генетик, биометрик, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх хүний эмзэг мэдээлэл нь хувь хүний нууцад хамаарна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

28 гишүүн дэмжиж, 55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтын “эрүү, иргэн, захиргааны болон бусад” гэснийг, 10.2 дахь хэсгийн “Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн тогтоосон” гэснийг тус тус хасаж, 10.2 дахь хэсгийн “ажилтны” гэсний дараа “зөвшөөрлөөр” гэж нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.1.5 дахь заалт нэмэх:

“10.1.5.Монгол Улсын Их Хурлын гишүүн хуралдааны ирцэд бүртгүүлэх, санал хураалт явуулах зорилгоор хүний биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг.” Санал гаргасан ажлын хэсэг. Энийг гүйцээн боловсруулах

чиглэл өгье. Энэ дээр чинь зөвхөн цаашдаа хурууны хээгээр биш нүүр, царай таньдаг программ ашиглахаар яриад байгаа шүү дээ. Энийг гүйцээн боловсруулъя. Их Хурлын юуг заавал оруулах хэрэг байна уу.

9.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийн “Энэ хуулийн 11.1, 11.3-т заасан зорилгоор” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

25 гишүүн дэмжиж, 55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10. Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “мэдээллийн эзний зөвшөөрлөөр” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

23 гишүүн дэмжиж, 53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Ирц муудаад байна ямар гишүүд гараад явчхав.

11.Төслийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалтын “бэлгийн чиг хандлага,” гэснийг “бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

25 гишүүн дэмжиж, 58.1 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа” гэснийг хасаж, 15.1.3 дахь заалтын “цуглуулснаас” гэснийг “цуглуулж, боловсруулснаас” гэж, “эсхүл гэрээнд заасан,” гэснийг “гэрээнд заасан, эсхүл харилцан тохиролцсон” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

26 гишүүн дэмжиж, 61.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Баасандоржоо энэ Хувь хүний нууцын тухай хууль гэж байгаа шүү дээ тийм ээ. Тэрэн дээр Хувь хүний нууцыг хамгаалах гэсэн хэсэг байгаа тиймээ. Хувь хүний нууцын тухай хууль дээр чинь саяын та нарын дурдсанаас чинь эрүүл мэнд, санхүү хөрөнгийн, гэр бүлийн нууцлалуудаа ингээд хаяад явчихаар чинь хүний санхүү дансны мэдээлэл. Тэгэхдээ хувь хүний нууц гэнэ гээд тодорхойлчихлоо шүү дээ. Тэр хэдийг. Хувь хүний нууцад хамаарна гээд 9.1 дэх заалтыг өөрчлөн найруулчихлаа шүү дээ. Бусад нь хамаарахгүй юм уу тэгэхээр. Тэрийг.

56.6 хувийн саналаар санал дэмжигдсэн. Түрүүн санал дэмжигдсэн.

13.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “мэдээллийн ангилал” гэснийг “мэдээллийн жагсаалт,” гэж, 19.4.7 дахь заалтын “мэдээлэл хариуцагчийн өгсөн үүрэг, зааврыг” гэснийг “мэдээлэл хариуцагчийн өгсөн үүрэг, чиглэл,

даалгаврыг” гэж тус тус өөрчилж, 19.3 дахь хэсгийн “шилжүүлсэн тохиолдолд мэдээлэл боловсруулагчид хүлээлгэх” гэснийг, 19.4.2 дахь заалтын “мэдээллийн эзний” гэснийг, 19.4.4 дэх заалтын “буцааж” гэснийг болон 19.6 дахь хэсгийг тус тус хасаж, 19.4.6 дахь заалтын “энэ хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу” гэсний дараа “мэдээллийн” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

28 гишүүн дэмжиж, 61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Төслийн 20 дугаар зүйлийн гарчгийн “Аюулгүй байдлыг” гэсний өмнө “Мэдээллийн” гэж, 20.1.1 дэх заалтын “мэдээллийн аюулгүй байдлыг хангах” гэсний өмнө “энэ хуулийн 20.2-т заасан шаардлагад нийцүүлэн” гэж тус тус нэмж, 20.1 дэх хэсгийн “чиглэлээр зохион байгуулалтын болон техникийн” гэснийг “талаар” гэж, 20.1.4 дэх заалтын “мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох талаар тодорхой журам” гэснийг “мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох талаар журам” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

22 гишүүн дэмжиж, 52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн “харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж тохиолдол бүрд агуулгад нь тохируулан өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт. Түвшинжаргалаа энэ яамны нэртэй холбоотой асуудлуудыг найруулгаар нэг мөсөн батлагдсаны дараа нийцүүлэх гэж. Одоо яг ингээд хууль нь батлагдаагүй байхад ингэхээр чинь бас дарааллын хувьд зөрчил үүсэж л байгаа юм байна.

22 гишүүн дэмжиж, 52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.2 дахь заалтын “мэдээллийг” гэсний өмнө “боловсруулсан” гэж нэмж, 21.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.2.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 21.1-д зааснаас бусад тохиолдолд мэдээллийн эзний мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглахад мэдэгдэл хүргүүлж болно.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

24 гишүүн дэмжиж, 58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 22 дугаар зүйлийн 22.6 дахь хэсгийн “бүртгэлийг жил бүр” гэснийг “бүртгэлийг жил бүрийн нэгдүгээр сард” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

26 гишүүн дэмжиж, 63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Энэ одоо санхүүгийн мэдээллийн алба энэ тэр гээд мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх тухай хуулиар гүйцэтгэх ажлын тухай хуулиар зохицуулагддаггүй мэдээлэл боловсруулдаг ажлууд байна шүү дээ. Зээлийн мэдээллийн сан, Санхүүгийн мэдээллийн алба энэ тэр гээд 5 сая төгрөгөөс дээш гүйлгээнүүдийг Санхүүгийн мэдээллийн албанд банкнаас шууд авдаг. Хянадаг боловсруулдаг ийм. Тэр энэ чинь энэ дотроо уялдуулахгүй бол.

Зээлийн мэдээллийн сан энэ тэр үү. Тэрэн дээр чинь төлбөртэй төлбөргүй энэ тэр гээд юмнууд яваад байна лээ шүү дээ.

18.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь заалтыг хасаж, 24.1.4 дэх заалтын “хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх” гэснийг “шаардлага, зөвлөмж өгөх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

23 гишүүн дэмжиж, 56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “дүрс бичлэгийн” гэснийг, 27.9 дэх хэсгийн “хандаж харах,” гэснийг болон 27.11 дэх хэсгийг тус тус хасаж, 27.4.3 дахь заалтын “нийтийн зориулалттай орон сууцны” гэсний дараа “орох, гарах нийтийн хэсэг болон дундын эзэмшлийн талбайн” гэж нэмж, 27.4.1 дэх заалтын “караоке” гэснийг “караокены өрөө,” гэж, 27.4.3 дахь заалтын “дүрст хэлбэрээр түгээх” гэснийг “дүрст хэлбэрээр тараах” гэж, 27.7 дахь хэсгийн “бичлэгийн системд” гэснийг “бичлэгийн төхөөрөмж байршуулахад” гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн 27.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 27.2 дахь хэсэг болгох:

“27.2.Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн систем нь энэ хуулийн 27.1-д заасан төхөөрөмж, мэдээлэл дамжуулах сүлжээ, хадгалах төхөөрөмж, программ хангамжаас бүрдэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

21 гишүүн дэмжиж, 51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Төслийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн “2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэснийг “2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

24 гишүүн дэмжиж, 58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Төслийн талаарх саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

25 гишүүн дэмжиж, 61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хууль зүйн байнгын хорооны дарга Сандагийн Бямбацогт.

С.Бямбацогт: Бид нар Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үндсэндээ хийгээд дуусаж байна. Энэ дээр сая таны ярьж байгаа асуудлаар 18 дугаар зүйл дээр мэдээлэл хариуцагчийн бас үүргүүд байж байгаа. Энэ мөнгө угаах терроризмтой тэмцэх замаар мөн саарал жагсаалт энэ тэр гээд асуудлууд яригддаг. Таны саяын ярьж байгаа зээлийн мэдээллийн сан ч гэдэг юм уу энэ асуудлуудаар бас тодорхой мэдээллийн эзний хүсэлтийн дагуу мэдээллийн хуулбарыг цахим хэлбэрээр үнэ төлбөргүй өгөх гэсэн заалт дээр бид нар эргэж харъя. Энийг та бас эцсийн хэлэлцүүлэгт анхааруулсан чиглэл өгөөч.

Г.Занданшатар: Тэгвэл нөгөө 912 үйлчилгээ цахим болж байгаа чинь бүгд үнэ төлбөргүй болчих асуудал үүснэ шүү дээ. Тэр чинь бас. Энийг сая Хууль зүйн байнгын хорооны даргын санал гаргасан асуудлаар дахин нягталж, гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. 18.2.11.

Төрийн цахим үйлчилгээнүүд чинь бүгд үнэ төлбөргүй болчихно байна шүү дээ. Энийгээ их тодорхой болгохгүй бол наад дээр чинь зөрчил үүсэж магадгүй.

Одоо найруулгын саналаар санал хураалт явуулъя.

Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн найруулгын санал:

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын “хөндөөгүй тохиолдолд” гэснийг “хөндөхгүйгээр” гэж, төслийн “дүрс бичлэг” гэснийг “дүрсний бичлэг” гэж тохиолдол бүрд агуулгад нь тохируулан тус тус өөрчлөх.

2.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтын “мэдээлэлд хүний оролцоогүй цахим хэлбэрээр хийх боловсруулалт нь” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Баасандоржоо төрийн үйлчилгээ үзүүлж байгаа улсууд чинь бас мэдээлэл хариуцагч байж болох байхгүй юу. Тэгэхээр үнэ төлбөргүй өгнө гэхээр төр хувийн хэвшил бүгдийг үнэ төлбөргүй өгнө гэж хуульчилж болох уу. Мэдээлэл боловсруулсан тийм учраас энийг сайн харах нь зүйтэй байх.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Хууль зүй, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “12.1, 12.3 дахь хэсгийн “Хувь хүний нууцын тухай” гэснийг “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” гэж,” гэснийг “12.1 дэх хэсгийн “хувь хүний нууцад хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хувь хүний нууцын тухай” гэснийг “хүний хувийн мэдээлэлд хамаарах бөгөөд түүнтэй холбогдох асуудлыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” гэж, 12.3 дахь хэсгийн “Хувь хүний нууцын тухай” гэснийг “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай” гэж” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

26 гишүүн дэмжиж, 63.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Гаалийн тухай хуулийн” гэсний дараа “5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсгийн “төр, хувь хүний, байгууллагын нууцад хамаарах мэдээллийг” гэснийг “төрийн болон албаны, байгууллагын нууц, хүний хувийн мэдээллийг” гэж, “нууцын хууль тогтоомжоор” гэснийг “холбогдох хууль тогтоомжоор” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

26 гишүүн дэмжиж, 63.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “хүний эмзэг мэдээллийг” гэснийг “хүний хувийн мэдээллийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

22 гишүүн дэмжиж, 55.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсгийн “төр, байгууллага, хувь хүний нууцтай” гэснийг “төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй” гэж” гэсний дараа “, “Захидал харилцааны нууцыг” гэснийг “Захидал харилцааны мэдээллийг” гэж” гэж. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

25 гишүүн дэмжиж, 62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төлийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.22 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн “дүрсний, дуу-дүрсний” гэсний өмнө “дууны,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

24 гишүүн дэмжиж, 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.22 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “орон байранд” гэснийг “нийтийн зориулалттай орон сууцанд оршин сууж байгаа” гэж, 2 дахь заалтын 6.27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг хөндөж” гэснийг “мэдээллийн эзний эрх, эрх чөлөөг зөрчиж,” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

23 гишүүн дэмжиж, 59.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.22 дугаар зүйлийн Тайлбар хэсгийн “караоке” гэснийг “караокены өрөө,” гэж өөрчилж,” “цахилгаан шат” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

21 гишүүн дэмжиж, 53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 6.27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

24 гишүүн дэмжиж, 60.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

25 гишүүн дэмжиж, 62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг,” гэснийг “38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсгийн “төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой” гэснийг “төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй холбоотой” гэж, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн “төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоос” гэснийг “төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй холбоотойгоос” гэж,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

24 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

1 дүгээр зүйлд “49 дүгээр зүйлийн 49.2.6 дахь заалтын “захидал харилцааны нууц” гэснийг “захидал харилцааны мэдээлэл” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

25 гишүүн дэмжиж, 62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн “111 дүгээр зүйлийн 111.6 дахь хэсгийн “төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцад” гэснийг “байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд” гэж” гэснийг “111 дүгээр зүйлийн 111.6 дахь хэсгийн “төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцад” гэснийг “төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлд” гэж” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

25 гишүүн дэмжиж, 62.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

Төслийн 1 дүгээр зүйлийн “Прокурорын тухай хуулийн 58 дугаар зүйлийн” гэсний дараа “58.3 дахь хэсгийн “захидал, харилцаа, хувийн нууц,” гэснийг “хүний эмзэг мэдээлэл,” гэж,” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг.

Захидал, харилцаа, хувийн нууц,” гэснийг “хүний эмзэг мэдээлэл,” гэж,” гэж нэмэх гэдэг чинь юу гэсэн үг юм. Өөрчлөх юм уу. Тэрэн дээрээ нэмж байгаа юм уу. Эмзэг мэдээлэл гэж нэмэгдэж байгаа гэсэн үг шүү дээ.

Санал хураалт.

Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Уучлаарай би нөгөө төхөөрөмждөө хүрч амжсангүй.

Тийм учраас дахиад санал хураалтыг хүчингүйд тооцож өгөөч. Би бол дэмжиж байгаа юм. Ажлын хэсгийн гишүүн учраас.

Г.Занданшатар: Хуулийн талаар ярьж байгаад хоцорсон л доо. Яриаг чинь би бүгдийг сонссон. Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна.

Энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Найруулгыг нь сайн бодоорой. Тэр хэсгийн гэсний дараа мэдээлэл гэж нэмэх юм уу. Гэснийг гэж нэмэх, гэсний дараа гэж байх ёстой байсан юм уу.

65 хувийн саналаар Сүхбаатар гишүүний санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн учраас дахин санал хураалт явуулъя.

25 гишүүн дэмжиж, 62.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан 7.1.10 дахь заалт нэмсүгэй:

1/7 дугаар зүйлийн 7.1.10 дахь заалт:

“7.1.10.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих,” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

24 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлд 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн “захидал харилцааны нууцыг” гэснийг “захидал харилцааны мэдээллийг.” гэж” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

23 гишүүн дэмжиж, 57.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Хууль зүйн болон, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “хүний эмзэг мэдээллийг” гэснийг “хүний хувийн мэдээллийг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

22 гишүүн дэмжиж, 55 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Хүүхдийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлд “7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “эрүүл мэнд, хувийн харилцааны нууц,” гэснийг “хувийн мэдээлэл,” гэж,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

22 гишүүн дэмжиж, 55 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

Энэ саналтай холбогдуулан Сандагийн Бямбацогт Хууль зүйн байнгын хорооны дарга үг хэлнэ.

Энэ дээр бас хуралдаан даргалагчаас чиглэл авах гэсэн юм.

Байнгын хороон дээр манай гишүүд ярьсан. Алтанхуяг гишүүн Сүхбаатар гишүүн, Энх-Амгалан гишүүн олон гишүүд бас ярьсан.

Төрийн нууцыг задрууллаа гээд иргэддээ төр маш хатуу хариуцлага хүлээлгэдэг. Төр маань өөрөө эргээд иргэдийнхээ хувийн нууцыг тэр дундаа хүний эмзэг мэдээллийг задалчхаад ямар нэгэн хариуцлага яригддаггүй. Тэгээд хохироод өнгөрдөг. Төр задалдаг, төрийн нэрийн өмнөөс төрийн албан хаагчид задалдаг. Мөн иргэд хоорондоо бие биеэ шантаажилдаг. Бас асуудал үүсдэг. Иймрхүү юман дээр

тодорхой хариуцлага хүлээлгэдэг байх ёстой. Тэгээд хариуцлагынх нь санкц хатуу чанга байхгүй бол энэ хууль маань бас амьдрал дээр бодитой хэрэгжихэд үр дүнгээ өгөхгүй гэдэг асуудал бас Байнгын хороон дээр яригдсан юм. Тэгээд түүнтэй холбоотойгоор энийг гүйцээн боловсруулах чиглэл өгөөд Эрүүгийн хуульд бас тодорхой зүйл заалтуудыг оруулах тал дээр Байнгын хороо ажлын хэсэг анхаарч ажиллах ёстой юм. Тийм болохоор энэ саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгнө үү.

Г.Занданшатар: Гурван саналыг гурвууланг нь. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр гаргасан зарчмын зөрүүтэй гурван саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгье. Гүйцээн боловсруулах чиглэл өгсөн учраас санал хураалт явуулахгүй.

Одоо хүүхдийн эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Зарчмын зөрүүтэй үлдсэн 1 саналаар санал хураалт явуулна.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн “эмзэг мэдээллийг” гэснийг “хувийн мэдээлэл” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг санал хураалт.

26 гишүүн дэмжиж, 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Эрүүгийн хэрэг Хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя. Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлд төслийн “1.11 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “захидал харилцааны нууцыг гэснийг “захидал харилцаан мэдээллийг” гэж нэмэх. Санал хураалт.

Энийг сайн нягталж хараарай. Ойлгомжтой бичиж байхгүй бол төслийн 1 дүгээр зүйлд “1.11 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1 дэх хэсгийн захидал харилцааны нууцыг гэснийг захидал харилцааны мэдээллийг гэж,” гэж нэмэх. Баахан нэр үг байж байснаа гэж нэмэх гээд явчхаж байгаа юм.

23 гишүүн дэмжиж 55.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хороонд шилжүүлэхийн өмнө саналын томьёоллуудынхаа найруулгыг эцэслэн сайн нягтлах хэрэгтэй юм байна шүү. Тэгвэл хууль дээрээ өөрчилсүгэй гэснийг. Эрүүгийн хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гэж байгаа байхгүй юу. Тэгээд хуульд өөрчлөлт оруулах тухай асуудлаар гэх байхгүй юу. Дандаа нэмэлт, өөрчлөлт гээд явчхаад байна.

Байнгын хорооны саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.